САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Чойжоо
Батсуурь СҮНДЭР

ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн баклаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Ч. Өнөрбаяр \Ph.D\

Улаанбаатар. 2026

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Чойжоо
Батсуурь СҮНДЭР

ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Мэргэжлийн индекс
042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : . . . . . Ч. Өнөрбаяр \Ph.D\
Шүүмжлэгч : . . . . . Л. Отгонбаяр \LL.M\

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЪЁГ

МЭДЭГДЭЛ i
ТАЛАРХАЛ ii
ТОВЧ ХУРААНГУЙ iii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ iv
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ vi
ОРШИЛ 1
Сэдэв сонгосон үндэслэл 1
Судлагдсан байдлын судалгаа 1
Судалгааны зорилго, зорилт 2
Судалгааны арга зүй 3
Судалгааны ажлын онол практикийн ач холбогдол 3
I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ 5
1.1. Даатгалын баталгааны онолын үндэс, эрх зүйн шинж 5
1.1.1. Даатгалын баталгаа ба түүний үүрэг 5
1.1.2 Даатгалын баталгааны ач холбогдол 7
1.1.3. Даатгалын баталгааны түүхэн хөгжил 8
1.1.4. Баталгаа, батлан даалт, даатгалын баталгааны ойлголт ба ялгаа 13
1.1.5. Банкны ба даатгалын баталгааны онцлог харьцуулалт 15
1.1.6. Даатгалын баталгаанд давхар даатгалын хэрэглээ 20
1.1.7. Даатгалын баталгааны төрөл ангилал (performance bond, bid bond, advance payment bond) 22
1.2 Зохицуулагч байгууллага 23
1.2.1. “Даатгалын тухай хууль”, “Санхүүгийн зохицуулах хорооны журам” 23
1.2.2. Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх зүйн орчин 25
1.2.3. “Төрийн худалдан авах ажиллагаанд даатгалын баталгаа 26
II БҮЛЭГ. ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ПРАКТИК АСУУДАЛ, ШИЙДЭЛ 28
2.1. Монголын даатгалын баталгааны зах зээл ба тулгамдсан асуудлууд 28
2.1.1. EPC/FIDIC гэрээний нөхцөл дэх даатгалын баталгаа 28
2.1.2. Олон улсын эрх зүйн зохицуулалт (EU, US Surety Bond law, UNCITRAL) 30
2.1.3. Даатгалын синдикатыг өрсөлдөөний эрх зүйн үүднээс шинжилсэн 33
2.1.4. Хэрэглэгчийн эрх ашиг: Банк ба даатгалын баталгаа 35
2.1.5. Хянан шалгагдаж буй маргааны дүн шинжилгээ 37
2.1.6. Гадаадын орнуудын даатгалын баталгааны эрх зүйн орчны харьцуулсан судалгаа 44
САНАЛ 54
ДҮГНЭЛТ 56
НОМЗҮЙ 57

МЭДЭГДЭЛ

Энэхүү бакалаврын дипломын төсөл нь зохиогчийн бие даасан оюуны бүтээл бөгөөд бусдын зохиогчийн эрхийг зөрчөөгүй болохыг баталж байна. Уг бүтээлийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) нь тус бүтээлийг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс олон улсын Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivatives (CC BY-NC-ND) лицензийн хүрээнд нийтэд түгээх, хадгалах эрхтэй.

Оюунтын нэр Б. Сүндэр Огноо: 2026.05.08

Гарын үсэг:

ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын дипломын төслийг амжилттай гүйцэтгэхэд эрдэм шинжилгээний арга зүйд сургаж, мэдлэг туршлагаа харамгүй хуваалцсан Хууль зүйн сургуулийн захирал Л.Отгонбаяр /LL.M/, болон багш Ч.Өнөрбаяр /Ph.D/ нартаа гүн талархаж буйгаа илэрхийлж байна. Та бүхний өгсөн зөвлөгөө, чиглүүлэг миний судалгааны ажлын гол тулгуур болсон билээ.

Мөн суралцах хугацаанд эрдэм мэдлэгийн суурийг минь тавьж өгсөн Хууль зүйн сургуулийн нийт багш нартаа, тусалж дэмжсэн гэр бүл, найз нөхөддөө чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсад хэрэглэгдэж буй даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт, түүний онолын үндэс, практик хэрэглээ болон тулгамдсан асуудлыг судлав. Даатгалын баталгаа нь гэрээний үүргийн биелэлтийг хангах, захиалагчийн эрх ашгийг хамгаалах, төслийн санхүүгийн эрсдэлийг бууруулах чиг үүрэг бүхий санхүү, эрх зүйн хэрэгсэл бөгөөд барилга, дэд бүтэц, төрийн худалдан авах ажиллагаа зэрэг салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Судалгааны хүрээнд Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох журмуудыг шинжилж, баталгаа, батлан даалт, банкны баталгаа болон даатгалын баталгааны эрх зүйн ялгаа, онцлогийг харьцуулан судалсан. Мөн олон улсын эрх зүйн зохицуулалт, тухайлбал FIDIC, ICC URDG 758, UNCITRAL болон Казахстан, ХБНГУ-ын туршлагыг авч үзэн Монголын эрх зүйн орчинтой харьцуулсан болно.

Түүнчлэн Монголын даатгалын зах зээл дэх практик хэрэглээ, даатгалын синдикат, давхар даатгалын хэрэглээ, банкны болон даатгалын баталгааны ялгаа, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой асуудлыг судалж, эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, практикт үүсч буй хүндрэлүүдийг тодорхойлов. Судалгааны үр дүнд Монгол Улсад даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх, давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэх, төрийн худалдан авах ажиллагаанд хэрэглэх эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Түлхүүр үгс: *Даатгалын баталгаа, баталгаа, батлан даалт, банкны баталгаа, давхар даатгал, төрийн худалдан авах ажиллагаа, эрсдэлийн удирдлага, даатгалын эрх зүй.*

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Мэсопотамийн шавар хавтан 8

Зураг 1.2 Монгол улсын даатгалын баталгааны төрлүүдийн эзлэх хувь.....29

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Орчин үеийн баталгаа 11
Хүснэгт 1.2 Тооцоолол.....39

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	**Тайлбар**
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
FIDIC	International Federation of Consulting Engineers.
EPC	Engineering, Procurement and Construction
ICC	International Chamber of Commerce
UNCITRAL	United Nations Commission on International Trade Law
URDG	Uniform Rules for Demand Guarantees
EU	European Union
US	United States
АРРФР	Агентство Республики Казахстан по регулированию и развитию финансового рынка
МЭГ	Монополын Эсрэг Газар

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Даатгалын баталгаа нь гэрээний үүргийн биелэлтийг санхүүгийн хувьд баталгаажуулдаг хэрэгсэл бөгөөд барилга, дэд бүтэц, төрийн худалдан авалт, EPC гэрээ зэрэг салбарт өргөн хэрэглэгддэг. Эдгээр гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Энэ нөхцөлд даатгалын баталгаа нь гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлэхгүй тохиолдолд захиалагчийн эрх ашгийг хамгаалж, санхүүгийн эрсдэлийг бууруулах чухал хэрэгсэл болж байдаг. Олон улсын FIDIC-ийн гэрээний стандарт нөхцөлүүдэд даатгалын баталгааг банкны баталгаатай ижил түвшинд хүлээн зөвшөөрдөг. Гэвч Монголын даатгалын зах зээл дээр энэхүү бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх аргачлал, давхар даатгалын тогтолцоо болон захиалагчийн зүгээс даатгалын баталгаанд итгэх итгэл сул байгаа нь төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Даатгалын баталгаа нь орчин үеийн санхүүгийн зах зээлд эрсдэлийг удирдах, төслийг санхүүжүүлэх, бизнесийн итгэлцлийг бий болгох чухал хэрэгсэл юм. Монгол Улсын даатгалын салбар сүүлийн жилүүдэд тогтмол хөгжиж байгаа ч даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт нь тулгамдсан асуудалтай хэвээр байна.

Монголын даатгалын зах зээл харьцангуй залуу, санхүүгийн бүтээгдэхүүний төрөл хязгаарлагдмал, даатгалын баталгааны үйлчилгээ хангалттай хөгжөөгүй зэрэг онцлогтой. Энэ нь хөрөнгө оруулалтын итгэлцэл, төслийн санхүүжилт, импорт-экспортын харилцаанд саад учруулж болзошгүй бөгөөд эрх зүйн зохицуулалт нь эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үндсэн ажиллагаа болдог.

Иймд Иргэний хууль болон Даатгалын тухай хуулийн зохицуулалтын хүрээн дэх “Даатгалын баталгаа”-ны эрх зүйн мөн чанарыг тодорхойлж, EPC/FIDIC гэрээний нөхцөлд хэрхэн үр дүнтэй хэрэглэх, тулгарч буй эрх зүйн саад бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон судалж байна.

Судлагдсан байдлын судалгаа

Монгол Улсад даатгалын баталгааны талаар тусгайлан судлагдсан эрдэм шинжилгээний бүтээл хязгаарлагдмал бөгөөд судалгааны ихэнх нь батлан даалт эсвэл банкны баталгааны хүрээнд хөндөгдсөн байдаг. Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын компани, Худалдан авах ажиллагааны газраас гаргасан тайлангуудад зах зээлийн статистик бий ч эрх зүйн гүнзгий дүн шинжилгээ тун цөөн. Харин олон улсын

түвшинд FIDIC, ICC, UNCITRAL-ийн баримт бичиг, бусад улс оронд даатгалын баталгааны системийн талаар хангалттай эх сурвалжууд бий. Олон улсын түвшинд хийгдсэн судалгаа, бүтээл, эрдмийн ажлуулаас дурдвал:

М. Хүслэн (2025), Даатгалын синдикат, Монгол Улсын даатгалын салбар дахь хөрөнгийн төвлөрөл бага, томоохон эрсдэлийг дангаар даах чадамж сул байгаа асуудлыг хамтын бүтэц буюу даатгалын синдикатаар шийдэх боломжийг судалсан. Иргэний хууль болон Өрсөлдөөний хууль хоорондын уялдаа, картелийн эрсдэлийг хөндсөн.

World Bank / IMF Reports Insurance Guarantee Schemes IGS (2023), Даатгалын компаниуд дампуурах эсвэл санхүүгийн чадамжгүй болох үед даатгуулагч болон гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах даатгалын баталгааны сангийн тогтолцоог хэрхэн үр дүнтэй байгуулах, түүний эрх зүйн бүтэц, татан буулгах явцын зохион байгуулалтыг судалсан. Олон улсын жишиг орнууд дээр тулгуурлан даатгалын баталгааны сангийн урьдчилсан болон дараах санхүүжилтийн загваруудыг харьцуулсан байдаг.

Jürgen Basedow Principles of European Insurance Contract Law (PEICL) Европын холбооны хэмжээнд даатгалын гэрээний эрх зүйн ерөнхий зарчмуудыг нэгтгэн загварчлах, гишүүн орнуудын даатгалын хууль тогтоомжийн зөрүүг арилгах боломжийг судалсан. Гэрээ байгуулахаас өмнөх мэдээлэл өгөх үүрэг, даатгалын тохиолдол, хохирлын үнэлгээ, регресс буюу суброгацийн эрх зүйн зохицуулалтуудыг тусгасан.

Судалгааны зорилго, зорилт

Даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт, хэрэглээг онол, хууль, практикийн түвшинд судлан, олон улсын эрх зүйн туршлагатай харьцуулж, Монгол Улсад энэ төрлийн баталгааг нутагшуулах, журамлах, бодит хэрэглээг хөгжүүлэх чиглэлээр санал боловсруулахад оршино.

- Даатгалын баталгааны онолын үндэс, эрх зүйн мөн чанарыг тодорхойлох;
- Монгол Улсад үйлчилж буй Иргэний хууль, Даатгалын тухай хууль, холбогдох журмуудад хийсэн зохицуулалтыг шинжлэх;
- Олон улсын эрх зүй болон ЕРС гэрээний нөхцөлд хэрэглэгддэг даатгалын баталгааны зохицуулалтыг харьцуулах;
- Монголын даатгалын баталгааны зах зээл, практик хэрэглээ, тулгамдсан асуудлыг илрүүлэх;

- Эрх зүйн сайжруулалт, шинэчлэлийн санал, зөвлөмж гаргах.

Судалгааны арга зүй

- Харьцуулсан судалгаа
- Өвөрмөц арга
- Асуулгын арга
- Анкетын арга

Дараах судалгааны аргыг ашигласан. Үүнд: Харьцуулсан судалгаа - Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг бусад улсын эрх зүйн орчинтой харьцуулан судлахад ашиглав.

Өвөрмөц арга - эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, эрх зүйн үзэгдлийн мөн чанар, ойлголтод товч тодорхойлолт өгөх

Асуулгын арга – судалгаанд оролцогчдоос тодорхой асуудлын талаар мэдээлэл, байр суурь цуглуулах зорилгоор ашиглав.

Анкетын арга – бүтэцчилсэн асуултын хүрээнд тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхэд хэрэглэв.

Судалгааны ажлын онол практикийн ач холбогдол

Энэхүү судалгааны ажлын онолын ач холбогдол нь иргэний эрх зүй болон даатгалын онолын дунд орших “даатгалын баталгаа” хэмээх институтын мөн чанар, эрх зүйн зохицуулалтын бүтцийг зааглан тодорхойлсонд оршино. Өнөөг хүртэл дотоодын сурах бичиг, судалгааны бүтээлүүдэд үүргийн гүйцэтгэлийг хангах аргууд болох “батлан даалт” болон “баталгаа”-ны зааг ялгааг зөвхөн банкны харилцааны хүрээнд авч үзэж ирсэн бол, энэхүү судалгаагаар даатгагчаас гаргаж буй баталгааны акцессор бус буюу бие даасан шинж чанарыг гүнзгийрүүлэн судалсан болно.

Уламжлалт даатгалын эрсдэлийг шилжүүлэх (Risk Transfer) зарчим болон даатгалын баталгаанд үйлчилдэг хохиролгүй байх (Zero-loss expectation), регресс журмаар эргэн нэхэмжлэх (Indemnity agreement) онолуудын харилцан хамаарлыг тодруулснаар санхүүгийн эрх зүйн онолын санг баяжуулахад хувь нэмэр оруулж байна. Мөн мэдээллийн тэгш бус байдлыг бууруулахад даатгагчийн гүйцэтгэх "андеррайтинг"-ийн чиг үүргийг эдийн засгийн онолын үүднээс тайлбарлаж, Монгол Улсын Иргэний хууль болон Даатгалын тухай хууль тогтоомж дахь нэр томьёоны зөрүүтэй байдлыг арилгах онолын суурь үндэслэлийг боловсруулсан.

Судалгааны ажлын бодит практик ач холбогдол нь Монгол Улсын бизнесийн орчин, ялангуяа төрийн худалдан авах ажиллагаа (тендер) болон барилга, дэд бүтцийн салбарт тулгарч буй санхүүгийн хүндрэлүүдийг шийдвэрлэхэд чиглэсэн арга замуудыг тодорхойлсонд оршино. 2024 оноос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар даатгагчийн баталгааг албан ёсоор зөвшөөрч эхэлсэн түүхэн үе шатанд хийгдэж буй энэхүү судалгаа нь бизнес эрхлэгчдэд ажлын капитал буюу эргэлтийн хөрөнгөө банканд бэлнээр байршуулахгүйгээр, зөвхөн эрсдэлийн хураамж төлж баталгаа гаргуулах санхүүгийн бодит гарцыг харуулсан.

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Даатгалын баталгааны онолын үндэс, эрх зүйн шинж

1.1.1. Даатгалын баталгаа ба түүний үүрэг

Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа нь даатгалын салбарт нэвтэрч буй санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ юм. Даатгалын баталгаа нь аж ахуйн нэгж байгууллага, иргэн гэрээгээр хүлээсэн үүргээ даатгалын компанид шилжүүлж, даатгалын компани нь гэрээнд заасны дагуу төлбөр төлөх баталгаа гаргахыг хэлнэ.[1] Даатгалын баталгаа нь уламжлалт даатгалаас зарчмын хувьд ялгаатай. Уламжлалт даатгал нь хоёр талт харилцаа байдаг бол даатгалын баталгаа нь гурван талт буюу үүрэг гүйцэтгэгч (principal), үүрэг гүйцэтгүүлэгч (beneficiary), даатгагч (surety) гэх гурвалсан харилцаа юм.[2] Даатгалын баталгаа нь ердийн даатгалын гэрээнээс ялгаатай нь эрсдэлийн шилжүүлэг бус, харин үүрэг гүйцэтгэхийг баталгаажуулах санхүүгийн хэрэгсэл юм. Манай улсын хувьд аж ахуйн нэгж байгууллага, иргэд аливаа тендерт оролцохдоо банканд бэлэн мөнгө байршуулах, эсвэл зээл авах хэлбэрээр банкны баталгаа гаргуулдаг байсан нь банкны баталгаанд хөрөнгөө түгжих, санхүүгийн боломжгүй бол тендерт оролцох ч боломжгүй болох зэрэг хүндрэл учруулдаг байсан.[3] Харин даатгалын байгууллагууд баталгаа гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тендерийн үйл ажиллагаандаа даатгалын баталгааг ашиглах болсноор иргэд, аж ахуйн нэгжүүдэд учирч болох хүндрэлийг эдийн засгийн хувьд зардал багатайгаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 50 орчим тэрбум төгрөгийн баталгаа гаргах боломжтой байна.

Даатгалын баталгаа нь эдийн засаг, санхүү, эрх зүй, даатгалын онолын хэд хэдэн суурь ойлголт дээр үндэслэдэг. Үүнд нь:

1. Эрсдэлийн шилжүүлэгийн онол (Risk Transfer Theory) нь даатгалын үндсэн суурь онол юм. Даатгалын салбарын гол зорилго нь тодорхойгүй байдлаас үүдэлтэй санхүүгийн алдагдлыг бууруулах, эрсдэлийг олон оролцогчид хуваарилах явдал байдаг. Даатгалын баталгаанд гэрээний үүрэг биелүүлэхгүй байх эрсдэл, төлбөрийн чадваргүй болох эрсдэл, гүйцэтгэлийн доголдол зэрэг эрсдэлүүд багтдаг. Даатгалын байгууллага эдгээр эрсдэлийг статистик мэдээлэл, санхүүгийн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ

[1] Санхүүгийн зохицуулах хорооны зурагт хуудас, Цуврал №25, https://frc.mn/#/home

[2] Ж.Оюунтунгалаг “Баталгаа”, https://legaldata.mn, 2016 он,

[3] Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас, 2023 он

ашиглан тооцдог. Ингэснээр даатгалын баталгаа нь эрсдэлийн шилжүүлгийн институц болж ажилладаг.[4]

2. Эрсдэлийг хуваарилах онол (Risk Pooling Theory) даатгалын дараагийн суурь онол юм. Даатгалын байгууллага олон байгууллагын эрсдэлийг нэг сан болгон нэгтгэдэг. Энэ зарчмыг статистикийн том тооны хууль (Law of large numbers) дээр үндэслэн тайрлбарладаг. Энэ онолын дагуу олон тооны даатгуулагчийн эрсдэлийг нэгтгэхэд нийт эрсдэлийн хэлбэлзэл буурдаг. Даатгалын баталгаанд олон гэрээний баталгаа гаргадаг, бүх гэрээ зөрчигдөх магадлал бага байдаг. Иймээс даатгалын байгууллага баталгааны хураамжийг тооцоолж, боломжит алдагдлыг санхүүжүүлэх боломжтой байдаг.[5]

3. Мэдээллийн эдийн засгийн онол (Information Economics) даатгалын баталгааны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн салбар бол мэдээллийн эдийн засаг юм. Энэ онолын гол асуудал бол мэдээллийн тэгш бус байдал юм. Энэхүү тэгш бус байдал нь даатгалын баталгааны салбарт хоёр гол эрсдэлийг дагуулдаг. Нэгдүгээрт, гэрээ байгуулахаас өмнө сөрөг сонголт (adverse selection) үүсдэг бөгөөд энэ нь санхүүгийн чадамж сул, эрсдэл өндөртэй компаниуд өөрсдийн бодит байдлыг нуун дарагдуулж, баталгаа гаргуулахыг илүүтэй эрмэлзэх үзэгдэл. Хоёрдугаарт, гэрээ байгуулсаны дараа ёс зүйн moral hazard үүсдэг бөгөөд баталгаа авсан гүйцэтгэгч компани “ямар ч асуудал гарсан даатгал төлнө” гэсэн сэтгэл зүйгээр ажилдаа хайнга хандаж, эрсдэлийг бодитоор нэмэгдүүлдэг. Тиймээс даатгалын компаниуд нь зөвхөн санхүүгийн үүрэг хүлээгч биш, харин аж ахуй нэгжүүдийн үнэн зөв мэдээллийг цуглуулж, шалгаж, зах зээлд найдвартай тоглогчдыг тодруулан шүүлтүүр хийдэг мэдээллийн сан юм.[6]

4. Ёс суртахууны эрсдэлийн онол (Moral Hazard Theory) даатгалын зах зээлд чухал асуудал бол moral hazard юм. Даатгалд хамрагдсан дараа эрсдэлтэй зан үйл нэмэгдэх. Даатгалын баталгаанд энэ эрсдэл дараах байдлаар илэрдэг. Гэрээ гүйцэтгэгч баталгаатай учир хариуцлага сулрах, ажлыг чанаргүй гүйцэтгэх зэрэг байдлаар илэрдэг. Иймээс даатгалын баталгаанд нөхөн төлбөрийн шаардах эрх, санхүүгийн ба гүйцэтгэлийн хяналт зэрэг арга хэрэгслүүдийг хэрэглэдэг. Эдгээр нь Moral hazard-ийг бууруудаг.[7]

---

[4] Allan H. Willet, “The Economic Theory of Risk and Insurance”, University of Pennsylvania Press, 1951 он

[5] Albrecht. P, "Not a Fallacy of the Law of Large Numbers: Pooling Risks and the Utility of Insurance", 2015 он

[6] Pierre-André Chiappori; Bernard Salanié, Testing for Asymmetric Information in Insurance Markets, 2001 он

[7] OECD “Working Papers on Finance, Insurance and Private Pensions” №31

1.1.2 Даатгалын баталгааны ач холбогдол

Даатгалын баталгаа нь орчин үеийн бизнесийн болон худалдан авах ажиллагааны харилцаанд оролцогч талуудын итгэлцлийг бэхжүүлэх, эрсдэлийг удирдах хамгийн чухал санхүүгийн хэрэгслүүдийн нэг юм. Энэ нь зөвхөн нэг талын ашиг сонирхлыг хамгаалаад зогсохгүй эдийн засгийн эргэлтийг хурдасгах ач холбогдолтой. Ач холбогдлыг нь дараах үндсэн хэд хэдэн чиглэлээр авах боломжтой.

1. Гэрээний талуудын хооронд мэдээллийн тэгш бус байдал, итгэлцлийн дутагдал байнга үүсдэг нөхцөлд гуравдагч этгээд болох даатгагч оролцож, үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс хариуцлага хүлээх баталгаа гаргах нь нөгөө талд итгэлцлийг бий болгодог. Ялангуяа барилга, дэд бүтэц, төрийн худалдан авалт зэрэг өндөр дүнтэй, урт хугацааны гэрээний хувьд онцгой ач холбогдолтой бөгөөд зөрчил гарсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх санхүүгийн эх үүсвэрийг урьдчилан бүрдүүлдэг.

2. Гэрээний үүргийг гүйцэтгэгч бүх эрсдэлийг дангаар үүрэхийн оронд түүний тодорхой хэсгийг даатгагчид шилжүүлснээр санхүүгийн дарамт буурч, бизнесийн үйл ажиллагаа тогтвортой явагдах нөхцөл бүрддэг. Даатгагч нь уг эрсдэлийг мэргэжлийн түвшинд үнэлж, шаардлагатай тохиолдолд давхар даатгалд хамруулснаар эрсдэлийг илүү өргөн хүрээнд тараан байршуулж, нийт санхүүгийн системийн эрсдэлийг бууруулдаг.

3. Бизнесийн санхүүжилийн хүртээмжийг нэмэгдүүлдэг. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд банкны баталгаа авахад шаардлагатай барьцаа хөрөнгө, зээлийн түүх дутмаг байх тохиолдолд даатгалын баталгаа нь илүү уян хатан нөхцөлтэй хувилбар болж өгдөг. Энэ нь зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлж, ялангуяа төрийн худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой.

4. Тендерийн баталгаа нь оролцогчдын хариуцлагагүй үйлдлээс сэргийлж, гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний биелэлтийг хангаж, урьдчилгаа төлбөрийн баталгаа нь төсвийн хөрөнгийг хамгаалдаг. Ийм механизмууд байхгүй тохиолдолд төрийн санхүүжилттэй төслүүдэд эрсдэл нэмэгдэж, төсвийн алдагдал үүсэх магадлал өндөр байдаг тул даатгалын баталгаа нь нийтийн эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болдог.

5. Үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргуулсан тохиолдолд гэрээг зөрчих эрсдэл буурдаг. Учир нь зөрчил гаргавал даатгагч нөхөн төлбөр хийсний дараа буцаан нэхэмжлэх журмаар гүйцэтгэгчээс буцаан нэхэмжлэх эрхтэй байдаг. Энэ нь үүрэг гүйцэтгэгчийг илүү хариуцлагатай, сахилга баттай ажиллахад хүргэж, нийт гэрээний харилцааны чанарыг сайжруулдаг.

6. Даатгалын байгууллагууд шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргах, эрсдэлийн үнэлгээний аргачлалаа сайжруулах, давхар даатгалын зах зээлтэй холбогдох зэргээр санхүүгийн салбарын гүнзгийрэлд хувь нэмэр оруулдаг. Энэ нь банк, хөрөнгийн зах зээлтэй уялдсан комплекс санхүүгийн экосистемийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Хэсгийн дүгнэлт: Даатгалын баталгаа нь орчин үеийн эдийн засагт олон талт үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гэрээний найдвартай байдлыг хангах, эрсдэлийг удирдах, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн худалдан авах ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн сахилга батыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих зэрэг өргөн хүрээний ач холбогдолтой.

1.1.3. Даатгалын баталгааны түүхэн хөгжил

Эртний гарал, үүсэл:

Баталгааны хамгийн эртний эх сурвалж нь батлан даалтын гэрээний бичгийн эх буюу **МЭӨ 2750** онд бичигдсэн Мэсопотамийн шавар хавтан юм. Аккад ба Шумерын хаан Саргон I-ийн номын сангаас ийм төрлийн гэрээний тухай бичээс олсон байдаг. Одоогоос бараг 4700 жилийн өмнө хийгдсэн энэхүү шавар хавтанд орчин үеийн даатгалын баталгааны олон шинж чанаруудыг агуулсан байдаг. Аккадын захын дүүрэгт амьдардаг нэгэн тариачин хааны цэргийн албанд татагдаж, тэрээр өөр нэг тариачинтай гэрээ байгуулж нөгөө тариачин нь цэрэгт явсан хүнийг эзгүйд фермийг нь арчилж тордохоор тохиролцсон байна. Тэрээр газрыг зохих ёсоор бордож, эд хөрөнгийг нь гэрээний хугацаа дуусахад анх хүлээн авсан шигээ эзэнд нь буцааж өгөх үүрэг хүлээсэн. Эзэн нь гэрээний биелэлтийг биечлэн хянах боломжгүй байсан тул баталгаажуулахын тулд Аккад хотын нэгэн худалдаачин батлан даагчаар оролцож, гэрээний биелэлтийг баталгаажуулсан тухай уг шавар хавтанд дурджээ.[8]

Зураг 1.1 *Мэсопотамийн шавар хавтан*





Эх сурвалж: World history encyclopedia, https://www.worldhistory.org/image/2786/terracotta-tablet-from nippur/?utm_source=chatgpt.com, 2025 он

[8] Wills D.Morgan, The History of Economics Suretyship, Cornell Law Review, 1927 он, 153 дахь тал

1889 онд МЭӨ 2400 оны үед хамаарах чулуун хавтан. Иракийн Ниппур хотод ажиллаж байсан хэсэг археологичид олжээ. **МЭӨ 2400** оны орчимд, Вавилоны хаан Дунгигийн хаанчлалын үед үр тарианы төлбөрийг батлан даасан баримт чулуун шахмал дээр бичигдсэн байдаг. Тухайн үед батлан даалтын баримтыг мэргэжлийн нотариатчид хоёр эсвэл гурван хувь үйлдэж, дөрвөн гэрчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулдаг байв.

Гэвч энэ гэрээ нь Саргон I хааны үеэс өмнө ч түгээмэл хэрэглэгддэг байсан бололтой. Саргон I-ээс ердөө 500 жилийн дараа батлагдсан Хаммурапийн хууль **(МЭӨ 2250 он)** нь 19-р зуунд хамаарах мэт төрийн үнэнч байдлын даатгалын тогтолцоог тусгасан байв.

Хаммурапийн хуулийн 22 ба 23 дугаар хэсэгт:

22. “Хэрэв хүн замын дээрэм үйлдэж байгаад баригдсан бол тухайн хүнийг цаазаар авна.”

23. “Хэрэв дээрэмчин баригдахгүй бол дээрэмдүүлсэн хүн бурханы өмнө алдсан зүйлсээ нэг бүрчлэн мэдүүлж, дээрэм гарсан муж, харъяаллын хот болон захирагч нь түүний алдагдлыг нөхөн төлнө.”[9]

Энэхүү сүүлийн заалтын дагуу хот болон захирагчийг батлан даагчийн байр сууринд тавьсан байна. Үүнээс гадна, энэ хэсэг нь батлан даалтын гэрээнд даатгалын зарчмыг хэрэглэж, хувь хүний хариуцлагыг хамтын хариуцлагаар сольсон байна. Хот нь өөрийн харьяаллын бүсэд орж ирсэн ямар ч хүний үнэнч байдлыг даатгаж, хариуд нь тухайн хотын харьяалалд байгаа хүн бүр бусдын шударга бус үйлдлээс хамгаалагдсан даатгалтай болж байв.

Хаммурапийн хуулиас хойш нэг мянган жилийн дараа буюу **МЭӨ 1300** оны орчимд Египетийн хаан II Рамзес болон Хитчүүдийн хаан Хаттусили нарын хооронд байгуулсан энхийн гэрээнд батлан даалтын шинж чанартай заалтууд багтсан байдаг. Халдейчуудын үед батлан даалтын гэрээ маш түгээмэл байсан бөгөөд тэдний үлдээсэн олон тооны шавар шахмалуудаас үүнийг харж болно. Нэгэн сонирхолтой жишээг дурдахад, нэгэн гэрээнд "Хэрэв зээлдэгч тогтоосон хугацаанд төлбөрөө төлөхгүй бол батлан даагч нь зээл болон хүүг бүрэн хариуцна" гэж заасан байдаг нь өнөөгийн банкны баталгаатай тун төстэй юм.

Грекийн түүхч Геродотын тэмдэглэсэн зүйл бол батлан даагч нь Вавилоны гэрлэлтийн зан үйлд чухал үүрэг гүйцэтгэдэг байжээ. Жил бүр гэрлэх насны

[9] Botsford, Source book of ancient history, 1912 он, 29 дэх тал

бүсгүйчүүдийг зах дээр цуглуулж, дуудлага худалдаагаар гэрлүүлдэг байв. Хамгийн үзэсгэлэнтэй бүсгүйг хамгийн өндөр үнэ өгсөн хүнд худалдаж, харин тэдгээр бүсгүйчүүдээс олсон мөнгөөр хөөрхийлөлтэй, царай муутай бүсгүйчүүдэд инж болгон өгч, ядуу эрчүүдтэй суулгадаг байв.

Херодот бичсэнээр: "Ямар ч эр хүн худалдаж авсан эмэгтэйгээ түүнийг эхнэрээ болгоно гэсэн батлан даагчийг гаргаж өгөхөөс нааш авч явах эрхгүй байсан." Хэрэв хожим нь хосууд хоорондоо таарамжгүй болж гэрлэлтээ цуцлавал, хуулиар өгөгдсөн батлан даалтын дагуу төлөгдсөн мөнгийг буцаан олгодог байжээ.[10]

МЭӨ 670 он хүртэлх хугацаанд батлан даалтын гэрээ бичгээр үйлдэгдсэн баримт олдоогүй байгаа нь тухайн үе хүртэл гэрээ голчлон аман хэлбэрээр хийгддэг байсныг илтгэж байна. Гэсэн хэдий ч Британийн музейд хадгалагдаж буй нэгэн шахмал нь бидний мэдэх хамгийн эртний бичгийн батлан даалтын гэрээ юм. Энэхүү баримт нь: "Пуду-Пиати-аас Силим-Ашур мөнгө хүлээн авав. Хэрэв Пуду-Пиати төлж чадахгүй бол Минухди-ана-или уг мөнгийг төлнө" гэж заасан байдаг. Энэхүү баримтыг МЭӨ 670 онд дөрвөн гэрчийн дэргэд үйлдсэн байна. Персүүд Вавилоны соёл иргэншлийг өвлөн авсан бөгөөд Куруш болон Дариус хааны эзэнт гүрний үед батлан даалтын гэрээг идэвхтэй хэрэглэж байсан олон тооны баримтууд Пенсильванийн их сургуулийн судалгаагаар олджээ.

Ром болон Карфагены хооронд **МЭӨ 509** онд байгуулсан анхны худалдааны гэрээнд: "Худалдаа хийхээр ирсэн хүмүүс хотын түшмэлийн дэргэд л арилжаа хийх ёстой бөгөөд төлбөрийг нь төрөөс батлан даана" гэсэн заалт байв. Энэ нь Хаммурапийн хуультай адилаар төрөөс баталгаа гаргаж байсан хэлбэр юм.

МЭӨ 180 онд Библид баталгааны тухай өгүүлдэг. Еврейчүүдийн дунд батлан даалт нь маш түгээмэл байсан бөгөөд тэд "гар барих" (striking hands) замаар гэрээгээ баталгаажуулдаг байв. Соломон хаан өөрийн "Сургаалт үгс" номондоо батлан даалтын аюул заналын талаар удаа дараа маш хатуу анхааруулж байсан нь уг харилцаа тухайн нийгэмд ямар их газар авсныг гэрчилдэг. Тэрээр:

"Хүү минь, хэрэв чи хөршийнхөө өмнөөс батлан даагч болж, танихгүй хүнтэй гар барин баталгаа гаргасан бол, чи амныхаа үгэнд урхидуулж, хэлсэн үгэндээ баригджээ" хэмээн сургаж байв. Мөн тэрээр *"Танихгүй хүний өмнөөс батлан даагч болох хүн заавал хохирол амсах болно; харин батлан даалтаас татгалзагч нь аюулгүй байна"* гэж анхааруулсан

[10] Wills D.Morgan, өмнөх эшлэл, 155 дахь тал

байдаг. Соломон хааны эдгээр сургаал нь батлан даалтыг бүр мөсөн хориглох гэхээсээ илүүтэйгээр, үүнээс үүдэх санхүүгийн асар их эрсдэл, магадгүй боолчлолд орох аюулаас иргэдээ хамгаалах зорилготой байв.

Библид баталгааны тухай өгүүлдэг. “Шударга хүн хөршийнхөө төлөө баталгаа болдог, харин бүдүүлэг хүн түүнийг орхих болно. Чиний батлан даагчийн нөхөрлөлийг бүү март, учир нь тэр чиний төлөө амиа өгсөн. Нүгэлт хүн батлан даалтынхаа сайн эд хөрөнгийг сүйрүүлэх болно. Мөн талархалгүй сэтгэлтэй хүн түүнийг орхих болно.

МЭ 150 оны орчимд Гайус гэх хүн өөрийн “Commentaries” бүтээлээ бичиж байх үед Ромчууд батлан даалтын маш нарийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлсэн байв. Батлан даагчийг ерөнхийд нь adpromissor гэж нэрлэдэг байсан бөгөөд тэдгээр нь дотроо гурван төрөлд хуваагддаг байв:

Sponsor: Зөвхөн Ромын иргэн байх ёстой бөгөөд зөвхөн аман гэрээнд баталгаа гаргадаг байв.

Fidepromissor: Ромын иргэн бус хүмүүс (peregrini) батлан даагч болох боломжтой байсан боловч зөвхөн аман гэрээнд хамаарна.

Fidejussor: Энэ нь хамгийн дэвшилтэт хэлбэр бөгөөд аман, бичгийн болон ямар ч төрлийн гэрээнд (зээл, ажил гүйцэтгэх гэх мэт) батлан даагч болох боломжтой байв.[11]

Ромчууд батлан даалтын анхны хуулиудыг боловсруулжээ.

Орчин үеийн баталгаа

Эрт үед баталгааны хэлбэрүүд нь хувь хүмүүс бие биенийхээ өмнөөс хариуцлага хүлээх зарчмаар явдаг байсан бол 19-р зуунаас корпорацын хэлбэрт шилжсэн.

Хүснэгт 1. *Орчин үеийн баталгаа*

Он	**Түүхэн шинэчлэл**
1837 онд	Анхны оролдлого буюу Уильям Л. Хаскинс Нью-Йорк хотод анхны баталгаат компани байгуулах санал гаргасан нь тухайн үедээ хувьсгал байв. Энэ нь хувь хүний баталгаанаас илүү найдвартай, институциональ систем рүү шилжих эхлэл байсан юм.

[11] Wills D.Morgan, өмнөх эшлэл, 156 дахь тал

1853 онд	Нью-Йоркт корпорацийн батлан даалтын компаниудыг байгуулахыг зөвшөөрсөн хуулийг баталсан.
1865 онд	Fidelity Insurance компани нь АНУ-ын анхны корпорацийн батлан даалтын компани болжээ.
1894 онд	АНУ-ын Конгресс Heard Act-ийг батлав. Энэхүү хуулиар холбооны төсвийн санхүүжилтээр хэрэгжих бүх барилга угсралтын төслүүдэд баталгаа заавал байхыг шаардах болсон.
1898 онд	American Surety Co. V. Pauly нь Дээд шүүхээр хэлэлцсэн анхны батлан даалтын хэрэг болсон.
1930 онд	Амиа хорлохын эсрэг батлан даалтын бичиг баримт бичигдсэн.
1931 онд	Батлан даалт, батлан даалтын тухай хуулийн гарын авлага хэвлэгдэж, батлан даалтын биелэлтийг тодорхойлсон.
1935 онд	АНУ-ын Конгресс Miller Act-ийг баталж, “100,000 ам.доллар ба түүнээс дээш хэмжээний нийтийн ажлын гэрээнд гүйцэтгэлийн баталгаа гаргах, 25,000 ам.доллараас дээш гэрээнд төлбөрийн баталгаа шаарддаг” зэргээр баталгааны төрлүүдийн суурийг тавьсан.
1942 онд	The National Association of Surety Bond Producers (NASBP) байгуулагдав.
2002 онд	Viking Bond Service-ийг Michael Herraren үүсгэн байгуулж, баталгааны бондын үйлчилгээ үзүүлэгчийн “цаасгүй” загварыг бий болгосон.
2003 онд	Travellers, AIG зэрэг 11 даатгалын компани хамтран баталгаа гарган Enron-ын үйлчлүүлэгчдэд урьд өмнө байгаагүй 600-650 сая ам.долларын төлбөр төлсөн.
2005 онд	Thomas Buckner нь баталгаат даатгалын салбарт олон жилийн туршлагатай мэргэжилтэн бөгөөд тэрээр Viking Bond Service-тэй нэгдэж компанид буюу барилга, дэд бүтцийн төслүүдэд нэн

	шаардлагатай төрлүүд болох Тендерийн баталгаа, Төлбөрийн баталгаа, Гүйцэтгэлийн баталгаа зэргийг хөгжүүлсэн.
2012 онд	The Small Business Administration (SBA) нь бизнесийн бүртгэлгүй компаниудад 250,000 доллар ба түүнээс бага үнэ бүхий баталгааг хялбаршуулсан журмаар олгож байсан.
2014 онд	ICC URDG 758 (2010)-г UNCITRAL дахин баталж, demand guarantee-ийн олон улсын стандарт болгон нотолсон. Олон улсын барилгын гэрээнд URDG 758 хэрэглэлт нэмэгдэж эхэлсэн.
2017 онд	FIDIC хоёрдугаар хэвлэлийг гаргасан ба FIDIC Red Book, Yellow Book, Silver Book.[12]

1.1.4. Баталгаа, батлан даалт, даатгалын баталгааны ойлголт ба ялгаа

Монгол Улсын Иргэний хуулийн 231-р зүйлд үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудийг хуульчилсан байдаг. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргууд дотор анз, дэнчин, баталгаа барьцаа, батлан даалт, эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ болох фидуци зэрэг нь багтана.

Монгол улсад өнөөдөр хэрэглэгдэж буй баталгааны эрх зүйн зохицуулалт нь 2002 оны Иргэний хуульд шинэчлэгдэж тусгагдсан зохицуулалт юм. УИХ-аас 1988 онд баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт “Иргэний хуулийг нийгмийн тодорхой харилцааг зохицуулах чиглэлээр иж бүрэн шинэчлэнэ”, түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Монгол улсын хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд Иргэний хууль болон бусад хуулиудыг багцлан боловсруулж батлуулна”[13] гэж тус тус заасныг үндэслэн Иргэний хуулийн төслийг боловсруулахад баталгааны зохицуулалтыг мөн шинэчилж тусгасан.

Тухайлбал үүргийн гүйцэтгэлийг хангах аргын талаарх зохицуулалтад үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргаж болох, баталгааны гэрээг заавал бичгээр хийх, гэрээнд өөрөөр заагаагүй бол баталгаа гаргагч нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхгүй байх, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардах, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн

[12] Viking Bond Service, infographic, 2016 он
[13] “Монгол Улсын Иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001-2002)”, 2018 он, 8 дахь тал

үүрэг хүлээсэн баталгаа гаргагч нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй байх талаар шинээр зохицуулсан. Өөрөөр хэлбэл энэхүү зохицуулалт нь 2002 оны Иргэний хуульд тусгагдсан шинэлэг зохицуулалт бөгөөд үйлчилж эхлээд хорин дөрвөн жил болж байна. Өмнө нь хэрэгжиж байсан хууль буюу 1994 оны Иргэний хуульд баталгааг "Үүрэг хүлээгч нь гүйцэтгэсэн ажил, шилжүүлсэн эд хөрөнгийн чанарын талаар тодорхой хугацаатайгаар баталгаа гаргаж болно. Энэ талаар үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэнэ[14]" гэж заасан байсан буюу гуравдагч этгээдэд баталгаа гаргах тухай бус өөрийн үүргийн баталгааны тухай зохицуулсан байсан. Өөрийн үүргийн баталгаа гэдэг нь нэгэнт байгуулагдсан байгаа гэрээний хүрээнд гэрээний нэг талын тухайн гэрээнээс үүдэлтэй эрхүүдийг хуульд тогтоосноос өөрөөр тогтоосон байхыг хэлнэ.[15] 1994 оны Иргэний хуульд тусгасан байсан чанарын баталгаа болох өөрийн үүргийн баталгааг 2002 оны Иргэний хуулийн 254 дүгээр 254.6 дахь хэсэг болон 254.7 дахь хэсэг, 349 дүгээр зүйлийн 349.2 дахь хэсгүүдэд баталгаат хугацаа гэх ойлголтоор хуульчилсан. Үүнээс авч үзвэл 1994 оны Иргэний хуульд зөвхөн чанарын баталгаа буюу өөрийн баталгааны тухай зохицуулсан бол 2002 оны Иргэний хуульд гуравдагч этгээд үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргаж болохоор зохицуулсан байна.

Энэ хуульчилсан зохицуулалт дотроос баталгааны гэрээг батлан даалтын гэрээнээс ялгах хэрэгтэй болдог. Практикт баталгааны гэрээг батлан даалтын гэрээтэй андуурах тохиолдол мөн их байдаг. Батлан даалтын гэрээнд баталгааны зохицуулалт тусгасан байх зэргээр илэрдэг. Тиймээс баталгааны зохицуулалтыг батлан даалтын зохицуулалттай харьцуулах нь зүйтэй.

Батлан даалтын хувьд хариуцлага нь дагалдах шинжтэй байдаг нь түүний онцлог. Үндсэн үүрэг гүйцэтгэгч хэдий хэмжээний төлбөр төлөх дутуу байна, батлан даагч зөвхөн тэр хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Энэ хариуцлага нь бие даасан бус үндсэн гэрээтэй шууд хамааралтай байдаг. Хэрэв үндсэн гэрээ хүчингүй болвол батлан даалтын үүрэг мөн адил хүчингүй болно, мөн үндсэн үүргийн хэмжээ өөрчлөгдвөл батлан даагчийн хариуцлага түүнийг дагаж өөрчлөгдөнө. Батлан даагч нь шинэ үүрэг үүсгэж буй бус аль хэдийн үүссэн үүргийг баталж буй хэрэг юм. Үндсэндээ үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

[14] 1994 оны Иргэний хуулийн 185 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
[15] Д. Янжинхорлоо, "Иргэний эрх зүйн үндсэн асуудал, үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүй", 2019 он, 187 дахь тал

Иргэний хуулийн 433 дугаар зүйлд Даатгалын баталгааны талаар зохицуулсан байдаг ба баталгааны гэрээний хувьд ийм үүрэг хүлээдэггүй бөгөөд үүргийн гүйцэтгэлийн үед бүхэлд нь үүрэг хүлээдэг бие даасан үүргийн хэлбэрт тооцогддог. Баталгааны үүрэг нь үндсэн гэрээнээс огт хамаарахгүй, тусдаа эрх зүйн харилцаа үүсгэдэг. Хэрэв үндсэн гэрээ хүчин төгөлдөр бус болсон, эсвэл маргаантай байгаа ч баталгааны нөхцөл хангагдсан бол баталгаа гаргагч төлбөр хийх үүрэгтэй хэвээр байна. Эндээс харахад батлан даалтын хувьд батлан даагчийн хариуцлага ихэвчлэн үндсэн үүргийн хэмжээгээр хязгаарлагддаг бөгөөд тэр нь үндсэн өр төлөгчийн үүрэгтэй салшгүй холбоотой байдаг. Баталгааны хувьд хариуцлагын хэмжээ нь гэрээнд урьдчилан тогтоогдсон дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд энэ нь үндсэн гэрээний үүргээс заавал хамаарах албагүй.

Мөн баталгаа болон батлан даалтын эрсдэлийн хуваарилалт нь эрс ялгаатай. Батлан даалтын үед батлан даагч нь зээлдүүлэгчид төлбөр хийхээс өмнө тодорхой хамгаалалт эдэлдэг, зарим тогтолцоонд “эхлээд үндсэн өр төлөгчид ханд” гэсэн шаардлага тавигддаг. Харин баталгааны үед баталгаа гаргагч ийм хамгаалалт бараг эдэлдэггүй. Шаардлага гарсан л бол шууд төлөх үүрэг хүлээдэг.

Хэсгийн дүгнэлт: Монгол Улсын Иргэний хуульд үүргийн гүйцэтгэлүүдийг хангах арга хэлбэрүүдийг цогцоор нь зохицуулсан ба баталгааны зохицуулалт нь 2002 оны хуулиар шинэчлэгдэн бие даасан шинжтэй зохицуулалт болж төлөвшсөн байна. Ялангуяа өмнөх 1994 оны Иргэний хуульд зөвхөн өөрийн үүргийн буюу чанарын баталгааг зохицуулж байсан бол шинэчлэсэн хуулиар гуравдагч этгээдээр дамжуулан үүргийн гүйцэтгэлийг хангах баталгааны харилцааг тусгайлан хуульчилсан нь эрх зүйн шинэчлэл болсон гэж үзэж болно. Мөн батлан даалт нь үндсэн үүргээс хамааралтай, дагалдах шинжтэй эрх зүйн хэрэгсэл бол баталгаа нь үндсэн үүргээс үл хамаарах, бие даасан төлбөрийн амлалт юм.

1.1.5. Банкны ба даатгалын баталгааны онцлог харьцуулалт

Банкны баталгаа болон даатгалын баталгаа нь аль аль нь гэрээний үүргийн биелэлтийг хангах зорилготой санхүүгийн хэрэгсэл боловч эрх зүйн зохицуулалт болон үнэ тарифын бүтцийн хувьд ялгаатай байдаг. Эдгээр ялгаа нь онолын төдийгүй практикт гэрээний талуудын эрсдэл, зардал, мөнгөн урсгалд шууд нөлөөлдөг ач холбогдолтой юм.

Юуны өмнө эрх зүйн зохицуулалтын хувьд банкны баталгаа нь бие даасан үүргийн шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл банк нь үндсэн гэрээнээс тусгаарлагдсан, өөрийн гэсэн бие даасан үүрэг хүлээдэг бөгөөд баталгааны нөхцөл хангагдсан тохиолдолд үндсэн

гэрээний маргаан, биелэлттэй холбоотой асуудлыг үл харгалзан төлбөр хийх үүрэгтэй. Энэ нь олон улсын практикт “on-demand” буюу шаардмагц төлөх зарчим гэж нэрлэгддэг.[16] Ийм нөхцөлд баталгааны ашиг хүртэгч тал зөвхөн баталгаанд заасан бичиг баримтыг бүрдүүлснээр банкнаас шууд төлбөр авах боломжтой бөгөөд банк тухайн маргааныг үнэн эсэхийг шалгах эрхгүй байдаг. Энэ нь банкны баталгаа маш өндөр итгэлцэл бүхий, эрсдэл багатай хэрэгсэл болгож өгдөг боловч нөгөө талаас банк өөрөө шууд санхүүгийн эрсдэл үүрдэг гэсэн үг юм. Банк нь баталгаа гаргахдаа үндсэн үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс гуравдагч этгээдийн өмнө төлбөрийн үүрэг хүлээж байгаа боловч уг үүргийг эцсийн байдлаар өөр дээрээ үүрэх зорилгогүй, харин тодорхой нөхцөл бүрдвэл гүйцэтгэгчийн өмнөөс түр хугацаанд санхүүгийн гүйцэтгэл хийж дараа нь үүссэн хохирлоо үндсэн үүрэг гүйцэтгэгчээс заавал гаргуулах зарчимтай ажилладаг үүнийг банк нь практикт “Банкны шаардах эрх” эсвэл “Үл маргах журмаар үүрэг гүйцэтгэгчээс суутгах эрх” гэж тодорхойлдог. Банкны баталгаа нь илүү шуурхай, хатуу шинж чанартай хэрэгждэг ба гурван үндсэн хэлбэрээр ангилдаг.

- Хамгийн түгээмэл буюу шуурхай хэлбэр нь бэлэн мөнгөн барьцаа буюу cash margin юм. Үүрэг гүйцэтгэгч баталгаа гаргуулахдаа банкинд тодорхой хэмжээний мөнгийг урьдчилан байршуулдаг бөгөөд банк баталгааны дагуу төлбөр хийсэн даруйд уг данснаас үл маргах журмаар шууд суутгал хийж өөрийн зардлыг нөхөн барагдуулдаг. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэгчтэй шүүхийн журмаар маргах шаардлагагүйгээр тухайн барьцаа данснаас төлбөрийг шууд татан авч хохирлоо барагдуулдаг.
- Үл хөдлөх болон бусад эд хөрөнгийн барьцаа нь буцаан нэхэмжлэх эрхийг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог. Үүрэг гүйцэтгэгч нь банкинд баталгаа гаргуулахдаа өөрийн өмч хөрөнгийг барьцаалж, баталгааны дагуу захиалагчид төлбөр төлсөн даруйд банк өөрт үүссэн шаардах эрхээ хэрэгжүүлж эхэлнэ. Үүрэг гүйцэтгэгч уг төлбөрийг сайн дураар нөхөн төлөхөөс татгалзвал банк Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн дагуу барьцааны зүйлийг шүүхийн буюу зарим тохиолдолд шүүхийн бус журмаар албадан борлуулж, үнийн дүнгээс нь өөрийн хохирлыг суутгадаг.
- Баталгааны дагуу гарсан төлбөрийг хугацаа хэтэрсэн өр төлбөрт хөрвүүлэх Contingent Liability to Loan Conversion механизм. Баталгааны гэрээний дагуу гарсан төлбөр нь үүрэг гүйцэтгэгчийн нэр дээр шууд өндөр хүүтэй, хугацаа

[16] ICC Uniform Rules for Demand Guarantees (URDG 758)

хэтэрсэн зээлийн өр төлбөр болон бүртгэгддэг. Энэ нь банк эрсдэлээ санхүүгийн бүтээгдэхүүн болгон хувиргах боломж олгодог бол нөгөө талаас үүрэг гүйцэтгэгч нь банкны зээлийн "хар жагсаалт"-д орж дансны зарлагын хөдөлгөөн хязгаарлагдах зэргээр санхүүгийн хүнд дарамтанд ордог нь гэрээний сахилга батыг хангах нөлөө үзүүлдэг.

Баталгааны эрх зүйн шинж нь үндсэн үүргээс үл хамаарах бие даасан шинжтэй байх ёстой боловч даатгалын баталгаа нь ердийн даатгалын гэрээний харилцаанд суурилж хэрэгжих тохиолдол түгээмэл байна. Даатгагч байгууллага нь шууд төлбөр хийх үүрэг хүлээдэггүй, харин бодит хохирол үүссэн эсэх, гэрээний үүрэг зөрчигдсөн эсэхийг шалгасны дараа нөхөн төлбөр олгодог. Өөрөөр хэлбэл, баталгааны дагуу төлбөр хийх эсэх нь зөвхөн бичиг баримтаас бус харин бодит нөхцөлд байдал, хохирлын үнэлгээнээс шууд хамаарна. Энэ нь даатгалын баталгааг илүү уян хатан, эрсдэлийг бодитоор үнэлдэг механизм болгодог боловч төлбөр авах үйл явц илүү удаан, маргаантай байх магадлалтай болгодог. Ердийн даатгалд эрсдэлд нөхөн төлбөр олгосноор харилцаа дуусгавар болдог бол, даатгалын баталгааны хувьд нөхөн төлбөр олгосноор буцаан нэхэх эрх шинээр үүсдэг. Монгол улсын Иргэний хуулийн ерөнхий зохицуулалт болон даатгалын эрх зүйн онолоор суброгаци эрх шилжих болон регресс буцаан нэхэмжлэх гэсэн ухагдахууны зааг дээр хэрэгждэг. Даатгалын баталгааны хүрээнд даатгагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс захиалагчид төлбөр гүйцэтгэх үүргийг тодорхой нөхцөлд хүлээдэг боловч энэ нь эрсдэлийг эцсийн байдлаар өөр дээрээ үүрч байна гэсэн үг биш бөгөөд түр хугацаанд санхүүгийн гүйцэтгэл хийж байгаа хэлбэр юм. Захиалагчид хохирлыг төлсөн даруйд захиалагчийн эдэлж байсан гүйцэтгэгчээс хохирол нэхэмжлэх хууль ёсны эрх нь даатгагчид шилждэг. Үүний үр дүнд даатгагч нь гүйцэтгэгчээс өөрийн гаргасан мөнгөн дүнг буцаан нэхэмжлэх бие даасан эрхтэй болдог.[17]

Банкны болон даатгалын баталгаанд буцаан нэхэмжлэх эрх нь баталгаа гаргагч этгээдийн эрсдэлийг эцсийн байдлаар үндсэн үүрэг гүйцэтгэгчид шилжүүлэх нийтлэг зорилготой боловч хэрэгжилтийн арга, эрх зүйн механикмын хувьд ялгаатай байна. Банкны баталгааны хувьд регрессийн эрх нь гэрээний нарийвчилсан зохицуулалт, данснаас шууд суутгал, барьцаа хөрөнгийн шуурхай хэрэгжилт зэргээр дамжуулан илүү хурдан, хатуу, шууд хэрэгждэг бөгөөд банк өөрийн эрсдэлийг бүрэн хамгаалсан бүтэцтэй байдаг. Харин даатгалын баталгааны хувьд регресс нь илүү уян хатан, гэрээний болон

[17] Tatjana Dimov, "Subrogation in insurance contract", 2018 он

шүүхийн журмаар хэрэгжих хандлагатай, зарим тохиолдолд хугацаа, зардал шаардсан процесс байдлаар илэрдэг.

Хоёрдугаарт үнэ тарифын хувьд ялгаа маш тодорхой харагддаг. Банкны баталгааны үнэ нь ихэвчлэн олон бүрэлдэхүүн хэсгээс тогтдог бөгөөд үүнд нэг удаагийн шимтгэл, жилийн шимтгэл, зарим тохиолдолд хүүгийн зардал, мөн нэмэлт үйлчилгээний төлбөрүүд ордог. Банк нь өөрийн хөрөнгөөр шууд төлөх эрсдэл хүлээдэг учраас эрсдэлийн үнэлгээ өндөр байдаг бөгөөд үүнтэй уялдан үнэ тариф харьцангуй өндөр тогтоогддог. Түүнчлэн банк ихэнх тохиолдолд барьцаа хөрөнгө шаардах эсвэл зээлийн шугам нээх шаардлага тавьдаг тул хэрэглэгчийн хувьд бодит зардлын бүтэц нь харьцангуй хүнд, олон шатлалт байдаг.

- Шууд шимтгэл (Commission fee): Банкны баталгааны шимтгэл нь ихэвчлэн жилийн 1.0% - 3.5% орчимд хэлбэлзэнэ.[18] Энэ хувь хэмжээ нь тухайн үйлчлүүлэгчийн зээлжих зэрэглэл (credit rating), төслийн эрсдэл, баталгааны төрөл (тендерийн, гүйцэтгэлийн...) болон барьцаа хөрөнгийн хөрвөх чадвараас хамаарч тогтдог.
- Алдагдсан боломжийн өртөг Opportunity Cost – Далд зардал: Энэ нь банкны баталгааны хамгийн өндөр жин дарах эдийн засгийн өртөг юм. Баталгаа гаргахадаа бэлэн мөнгө эсвэл үл хөдлөх хөрөнгө барьцаалдаг. Хэрэв аж ахуйн нэгж 100 сая төгрөгийг барьцаалуулан банкинд түгжвэл, уг хөрөнгийг бизнесийн эргэлтэд оруулж болох байсан ашгаа алдаж байна гэсэн үг.
- Гүйлгээний болон нэмэлт зардлууд (Transaction costs): Барьцаа хөрөнгийн үнэлгээ хийлгэх хураамж, нотариатын төлбөр, улсын бүртгэлийн хураамж, барьцаа хөрөнгийн даатгалын төлбөр зэрэг нь үйлчлүүлэгчийн санхүүгийн ачааллыг нэмэгдүүлдэг.

Харин даатгалын баталгааны үнэ нь даатгалын хураамж хэлбэртэй байдаг бөгөөд ихэвчлэн харьцангуй бага хувьтай тогтоогддог. Даатгагч нь бүх баталгаанд төлбөр хийхгүй, зөвхөн эрсдэл бодитоор үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгодог тул нийт эрсдэлийг тархааж, хураамжийг бага түвшинд барих боломжтой байдаг. Мөн ихэнх тохиолдолд барьцаа хөрөнгө шаардахгүй эсвэл маш бага шаардлага тавьдаг нь бизнес эрхлэгчдийн хувьд мөнгөн урсгалд эерэг нөлөө үзүүлдэг. Гэсэн хэдий ч даатгалын компани нь андеррайтинг буюу эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийдэг тул зарим өндөр

[18] Худалдаа хөгжлийн банкны цахим хуудас, https://www.tdbm.mn/mn/corporate/khudaldaany-sankhuuzhilt/banknii-batalgaa

эрсдэлтэй төслүүдэд хураамж өсөх, эсвэл баталгаа олгохоос татгазах магадлалтай байдаг.

- Даатгалын хураамж Premium: Даатгалын баталгааны жилийн хураамж нь ихэвчлэн 0.5% - 2.5% орчимд байдаг[19]. Энэ нь банкны шууд шимтгэлтэй ойролцоо боловч даатгалын компаниуд эрсдэлийг давхар даатгалд байршуулж чадсан тохиолдолд хураамжийн хэмжээг бууруулах уян хатан боломжтой.
- Капиталын үр ашигтай байдал Capital Efficiency : Даатгалын байгууллагууд банк шиг 100% бэлэн мөнгө эсвэл үл хөдлөх хөрөнгө түгжихийг шаарддаггүй. Тэд үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан, нэр хүнд, өмнөх гүйцэтгэлийн түүхийг шалгасны үндсэн дээр баталгаа гаргадаг. Ингэснээр үйлчлүүлэгч бэлэн мөнгөө бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломжтой.
- Далд зардалгүй: Үйлчлүүлэгч зөвхөн тогтоосон даатгалын хураамжийг төлөх бөгөөд хөрөнгөө түгждэггүй тул алдагдсан боломжийн өртөг нь тэгтэй тэнцүү байдаг.

Банкны болон даатгалын баталгааны үнэ тарифын ялгаа нь зөвхөн хувь хэмжээний зөрүү биш, харин капиталын удирдлагын үр ашгийн ялгаа юм. Банкны баталгаа нь “хөрөнгийг царцаах” замаар бизнесийн өсөлтийг түгждэг санхүүгийн өндөр өртөгтэй хэрэгсэл бол, даатгалын баталгаа нь цэвэр эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж бэлэн мөнгөний урсгалыг чөлөөтэй үлдээдэг эдийн засгийн хувилбар юм. Олон улсын практикт, ялангуяа Хойд Америк болон Европын зах зээлд, аж ахуйн нэгжүүд банкны зээлийн хязгаарт нөлөөлөхгүй, барьцаа хөрөнгө шаарддаггүй зэрэг санхүүгийн давуу талаас шалтгаалан даатгалын баталгааг сонгодог. Гэхдээ захиалагчийн үүднээс авч үзвэл on-demand шинж чанартай банкны баталгаа илүү шуурхай хамгаалалт олгодог тул Ази болон Дорнод дахинд банкны баталгаа давамгайлсаар байна.

Банкны баталгаа өндөр өртөгтэй боловч шуурхай, өндөр итгэлцэл бүхий хэрэгсэл байдаг бол даатгалын баталгаа харьцангуй хямд боловч төлбөрийн процесс илүү удаан, нөхцөлтэй байдагт оршино. Эцэст нь дүгнэж хэлэхэд, банкны баталгаа эрсдэлийг банкинд төвлөрүүлж, захиалагч талын эрх ашгийг илүү хамгаалдаг хатуу механизм бол даатгалын баталгаа нь эрсдэлийг илүү зах зээлийн зарчмаар хуваарилж, зардлын хувьд илүү уян хатан шийдэл болж өгдөг. Иймээс аль хэрэгсэлийг сонгох нь тухайн гэрээний

[19] Хаан даатгалын цахим хуудас, 2026 он, https://www.e-batalgaa.mn (Сүүлд үзсэн: 2026.05.232)

шинж чанар, талуудын итгэлцлийн түвшин, санхүүгийн боломж, эрсдэлийн хүлээх чадвараас шууд хамаардаг.

1.1.6. Даатгалын баталгаанд давхар даатгалын хэрэглээ

Санхүүгийн зах зээлд эрсдэл гэдэг зүйл хэзээ ч алга болдоггүй, харин нэг субъектээс нөгөөд шилжиж, хуваарилагдаж байдаг жамтай. Даатгалын баталгаа ба давхар даатгал нь яг энэ эрсдэлийг хуваалцах, тараан байршуулах замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чухал механизм болдог.

Давхар даатгал гэдэг нь даатгалын компани өөрийн хүлээсэн эрсдэлийн тодорхой хэсгийг өөр нэг даатгагчид шилжүүлэх үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл даатгалны компани өөрөө даатгуулагч болж өөрийн эрсдэлийг тараан байршуулж байгаа хэлбэр юм. Энэ нь даатгалын компани санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах, нэг том эрсдэлээс болж дампуурахаас сэргийлэх, мөн илүү том хэмжээний даатгалын гэрээ байгуулах боломжийг бүрдүүлдэг. Энгийнээр хэлбэл давхар даатгал бол “Даатгалын компаниудын даатгал” юм. Хэрвээ том хэмжээний хохирол (байгалийн гамшиг, томоохон үйлдвэрийн осол эсвэл гэрээний том зөрчил) нэгэн зэрэг тохиолдвол анхдагч даатгалын компани өөрөө дампуурах аюултай.

Тиймээс даатгалын компани нь өөрийн дааж чадахаас хэтэрсэн эрсдэлээ дэлхийн хэмжээний давхар даатгалын компаниудад (Munich Re, Swiss Re гэх мэт) шилжүүлж, хураамжийнхаа тодорхой хувийг тэдэнд төлдөг.

Даатгалын баталгааны зах зээлд давхар даатгал яагаад хэрэгтэй байдаг гэдгийг дөрвөн үндсэн өнцгөөр тайлбарлаж болно.

1. Даатгалын баталгаа нь өөрөө “Зээлийн шинж чанартай” эрсдэл юм. Жишээ нь улсын хэмжээний том дэд бүтцийн төсөл болох цахилгаан станц эсвэл олон улсын хэрдны замын бүтээн байгуулалтад олгож буй гүйцэтгэлийн баталгааны дүн хэдэ зуун сая ам.доллароор хэмжигдэнэ. Хэрэв гүйцэтгэгч компани ажилаа дуусгаж чадалгүй default болбол захиалгч тал баталгаа гаргасан даатгалын компаниас нэхэмжилнэ. Анхдагч даатгалын компанид ийм хэмжээний мөнгийг шууд гаргах бэлэн мөнгөний нөөц байхгүй байж болно. Энэ үед давхар даатгалын гэрээ ажиллаж, хохирлын дийлэнх хувийг давхар даатгагч гаргаж өгснөөр анхдагч даатгалын компани санхүүгийн хямралд орохоос бүрэн сэргийлдэг.

2. Даатгалын компани болгон өөрийн хөрөнгийн хэмжээнээс хамаарч “хүлээх авах боломжтой эрсдэлийн дээд хязгаар”-тай байдаг. Давхар даатгалгүйгээр даатгалын

компани нь жижиг хэмжээний тендерийн баталгаанаас хэтэрч чадахгүй. Харин ардаа давхар даатгалын хүчирхэг хамгаалалттай болсноор тухайн компани маш том хэмжээний төслүүдэд баталгаа гаргах чадамжтай болдог. Өөрөөр хэлбэл даьхар даатгал нь дотоодын даатгалын компаниудад “өөрийн жингээсээ давсан” том дүнтэй баталгаануудыг гаргах боломжийг нээдэг гэсэн үг.

3. Олон улсын давхар даатгагчид дэлхий даяар олон мянган баталгаат төслүүд дээр ажиллаж үзсэн асар их туршлагатай байдаг. Анхдагч даатгалын компани ямар нэгэн эрсдэлтэй, эсвэл урьд өмнө хийж байгаагүй шинэ төрлийн төсөлд баталгаа гаргах гэж байгаа бол давхар даатгагчдад хандаж эрсдэлийн үнэлгээ хийлгэдэг. Давхар даатгагчид тухай төслийн санхүүгийн бодит чадвар, гэрээний нөхцөлийг шинжлэхэд нь тусалж, мэргэжлийн зөвлөгөө өгдөг нь дотоодын даатгагчдыг буруу шийдэр гаргахаас хамгаалдаг үл үзэгдэх шүүлтүүр болдог.[20]

4. Практикт даатгалын баталгааны давхар даатгал нь хоёр янзаар хэрэгждэг.

Гэрээт давхар даатгал (Treaty): Даатгалын компани жилийн турш гаргах тодорхой хэмжээний стандарт баталгаанууудыг шууд автоматаар давхар даатгуулахаар урт хугацааны гэрээ хийхийг хэлнэ.

Факультатив давхар даатгал (Facultative): Маш том, онцгой эрсдэлтэй ганц төсөлд зориулж тусгайлан нэг удаагийн давхар даатгал хийхийг хэлнэ. Энд давхар даатгагч тухайн төслийг нэг бүрчлэн судалж байж зөвшөөрдөг.[21]

Эцэст нь дүгнэж хэлэхэд, даатгалын баталгаа нь гэрээний үүргийн биелэлтийг хангах даатгалын тусгай хэрэгсэл бол давхар даатгал нь тухайн баталгаанаас үүсэх эрсдэлийг даатгалыг компани өөрөөсөө цааш тараан хуваарилах механизм юм. Энэ хоёрын уялдаа нь даатгалын зах зээлийн тогтвортой байдал, томоохон төслүүдийг санхүүгийн баталгаагаар хангах боломжийг бий болгодог стратегийн ач холбогдолтой бөгөөд орчин үеийн санхүүгийн системд зайлшгүй шаардлагатай механизм гэж үзэж болно.

[20] Swiss Re цахим хуудас, 2026 он, https://corporatesolutions.swissre.com/insurance-solutions/credit-surety/surety.html
[21] Smart asset цахим хуудас, Facultative vs. Treaty Reinsurance: What’s the Difference? , https://smartasset.com/financial-advisor/facultative-vs-treaty-reinsurance-whats-the-difference

1.1.7. Даатгалын баталгааны төрөл ангилал (performance bond, bid bond, advance payment bond)

Даатгалын баталгааг хэрэгжиж буй төслийн үе шатаас хамааран доорх үндсэн төрлүүдэд хуваагддаг. Эдгээр баталгааны төрлүүд нь худалдан авах ажиллагаанаас эхлээд төсөл бүрэн дуусах хүртэлх бүх үе шатыг хамардаг эрх зүйн цогц систем юм.

1. Тендерийн баталгаа (Bid bond)

Тендерийн баталгаа нь “гэрээ байгуулах үүргийг баталгаажуулах”-д оршдог. Худалдан авах ажиллагаа буюу тендер шалгаруулалтын явцад оролцогч компаниуд үнийн санал болон техникийн нөхцөлөө ирүүлэхдээ уг баталгааг хавсаргадаг. Эрх зүйн үүднээс авч үзвэл, тендерийн санал бол Иргэний хуулийн утгаараа “оффэр” буюу гэрээ байгуулах албан ёсны санал юм. Хэрэв тухайн компани тендерт ялсан атлаа гэрээ байгуулахаас татгалзах, эсвэл саналаасаа буцах тохиолдолд захиалагч тал тендерийг дахин зарлах, цаг хугацаа алдах зэрэг бодит хохирол амсдаг. Тендерийн баталгаа нь яг энэ эрсдэлийг хууль зүйн хувьд хааж өгдөг. Даатгалын компани амлалт өгч буй хэрэг юм. Тиймээс уг баталгаа нь зөвхөн тендер шалгаруулалтын үе шатанд үйлчлэх богино хугацааны эрх зүйн зохицуулалт болдог.

2. Гүйцэтгэлийн баталгаа (Performance bond)

Гүйцэтгэлийн баталгаа нь тендерт ялж үндсэн гэрээ байгуулагдсаны дараа Гүйцэтгэлийн баталгааны эрх зүйн харилцаа эхэлнэ. Гүйцэтгэлийн баталгаа нь “гэрээнд заасан техникийн нөхцөл, чанар, хугацааны стандартыг хангах” амлалт юм. Гүйцэтгэгч гэрээний дагуу ажлаа зохих ёсоор, хугацаанд нь, чанарын шаардлага хангаж гүйцэтгэх үүрэгтэйг баталгаажуулдаг. Хэрэв гүйцэтгэгч үүргээ биелүүлэхгүй бол захиалагч нь даатгагчид хандан нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй болно. Гэхдээ онцлох нэг зүйл нь даатгагч шууд төлбөр хийхээс өмнө тухайн үүрэг үнэхээр зөрчигдсөн эсэх, хохирол бодитоор үүссэн эсэхийг шалгах эрхтэй байдаг.

3. Урьдчилгаа төлбөрийн баталгаа (Advance payment bond)

Урьдчилгаа төлбөрийн баталгаа нь “зориулалтын дагуу ашиглах ба буцаан төлөх үүргийг хангах”-д оршино. Томоохон төслүүдэд захиалагч тал гүйцэтгэгчид ажил эхлүүлэхэд нь зориулж урьдчилгаа мөнгө олгодог. Тухайн мөнгийг зориулалтын дагуу ашиглах, эсвэл үүргээ биелүүлээгүй тохиолдолд буцаан төлөхийг баталгаажуулах зорилготой. Хэрэв гүйцэтгэгч үүргээ биелүүлэхгүй бол даатгагч тухайн урьдчилгаа төлбөрийн хэмжээг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Энэ баталгаа нь “unjust enrichment” буюу үндэслэлгүйгээр

хөрөнгөжих эрсдэлийг бууруулах, мөн санхүүгийн сахилга батыг хангах эрх зүйн хэрэгсэл болдог.

Дүгнэж хэлэхэд, нэг талаас даатгалын зарчмаар эрсдэлийг үнэлж, хураамж авдаг, нөгөө талаас баталгааны зарчмаар гуравдагч этгээдийн өмнө үүрэг гүйцэтгэх баталгаа гаргадаг. Гэхдээ банкны баталгаанаас ялгаатай нь даатгалын баталгаа ихэвчлэн “нөхөн төлбөрийн” шинжтэй бөгөөд шууд маргаангүй төлбөр хийх үүрэг биш, харин бодит нөхцөл байдлыг шалгасны үндсэн дээр төлбөр төлөх үүрэгтэй байдаг.

Эдгээр бүх баталгааны ард үйлчилдэг хамгийн чухал зарчим бол суброгаци (subrogation) буюу эрх шилжих зарчим юм. Даатгалын компани захиалагчийн хохирлыг барагдуулсны дараа хууль зүйн хувьд захиалагчийн байр сууринд очиж, гэм буруутай гүйцэтгэгч компаниас өөрийн гаргасан мөнгийг нэхэмжлэх эрхтэй болдог. Эцэст нь хэлэхэд эдгээр даатгалын баталгаануудын гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах, гэрээний өмнөх болон дараах үе шатны эрсдэлийг бууруулах, мөн талуудын хоорондын итгэлцлийг институцийн түвшинд хангах зорилготой, даатгал болон баталгааны шинжийг хослуулсан цогц эрх зүйн механизм юм. Эдгээр нь барилга, дэд бүтэц, төрийн худалдан авалт, олон улсын гэрээнд зайлшгүй шаардлагатай хэрэгсэл болж эдийн засгийн эргэлтийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

1.2 Зохицуулагч байгууллага

1.2.1. “Даатгалын тухай хууль”, “Санхүүгийн зохицуулах хорооны журам”

Даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсад зөвхөн иргэнийй эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарлах боломжгүй бөгөөд салбарын тусгай зохицуулалт болох “Даатгалын тухай хууль” болон “Санхүүгийн зохицуулах хороо”-оос гаргасан багц дүрэмтэй нягт уялдуулан авч үзэх шаардлагатай байдаг.

Даатгалын тухай хууль нь даатгалын баталгааны эрх зүйн орчныг тодорхойлох үндсэн эх сурвалжийн нэг юм. ДтХ-ийн 4.1.13-т даатгагчийн баталгаа гэх ойлголтыг тодорхойлсон нь даатгалын баталгааг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд бие даасан хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн чухал зохицуулалт болсон. Уг заалтад даатгагч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагын дагуу үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөр гүйцэтгэх, үүний зэрэгцээ үүрэг гүйцэтгэгч нь даатгагчид эргэн төлбөр төлөх үүрэг хүлээхээр заасан байна. Энэ нь даатгалын баталгаа нь Иргэний хуулийн үүргийн гүйцэтгэлийг хангах арга (баталгаа, батлан даалт) -ын мөн чанарыг агуулахын зэрэгцээ даатгалын байгууллагын эрсдэл үнэлэх, хураамж авах зэрэг үйл ажиллагааны онцлогтой

хосолж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, даатгалын баталгаа нь эрсдэлийг үнэлж хураамжийг тооцох замаар гуравдагч этгээдийн өмнө бие даан мөнгөн хариуцлага хүлээдэг, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн батлан даалтын өвөрмөц хэрэгсэл гэж үзэх боломжтой.

ДтХ-ийн $6^1.1$-т "*Даатгагч нь энэ хуулийн 4.1.1-д зааснаас гадна холбогдох этгээдээс бусад этгээдэд дараах даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно*" гэж зааснаар даатгагч нь өөрийн холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах эрхтэй бөгөөд уг харилцаанд $6^1.2$-т зааснаар Иргэний хуулийн 457 дугаар зүйлийн зохицуулалтыг баримтлахаар хуульчилсан байна. Хууль тогтоогчийн зүгээс даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор эрсдэлийг хязгаарлах механизмыг хуульчилсан. Тухайлбал ДтХ-ийн $6^1.4$-т зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны хүрээнд гаргах баталгааны дүн нь даатгагчийн тусгайлсан эрсдэлийн сангаас давсан тохиолдолд заавал эрсдэлийн үнэлгээ хийж, давхар даатгалд хамруулахыг шаарддаг.

Тус хуулийн $6^1.3$-т заасан бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлдэг. Уг харилцааг Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүлйийн 14.1, 14.2.22-т заасны дагуу "Даатгалын багц дүрэм"-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох "Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам"-аар нарийвчлан зохицуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргадаг Даатгалын багц дүрмийн 17 дугаар хавсралтад "Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам"-ын тухай заасан байдаг ба дараах үндсэн шалгууруудыг хангах үүрэгтэй.

- Даатгагч нь баталгаа гаргах үйл ажиллагааг хариуцан бие даасан нэгжтэй байхын зэрэгцээ Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) -өөрөө батлуулсан эрсдэлийн удирдлагын бодлого, үүрэг гүйцэтгэгчийг таньж мэдэх аргачлал бүхий дотоод журамтай байна.
- Даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн 70 хувиас хэтрэхгүй байх хязгаартай. Түүнчлэн баталгаа гаргах үед тухай компани Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралтад заасан төлбөрийн чадварын I эсвэл II дугаар түвшинд байх шаардлагатай бөгөөд баталгааны үнийн дүн нь тухайн гэрээний нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байх ёстой.

- Баталгаа гаргагч компаниуд хамтран эрсдэлийн болон мэдээллийн нэгдсэн санг удирдах хамтын бүтцийг бий болгох үүрэгтэй бөгөөд тайлан мэдээллийн сар, улирал тутамд Санхүүгийн Зохицуулах Хороонд цахимаар тайлагнадаг байна.

1.2.2. Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх зүйн орчин

Даатгалын үйл ажиллагаа, тэр дундаа даатгалын баталгаа гаргах эрх нь Даатгалын тухай хуульд заасны дагуу тусгайлан журамлагдсан үйл ажиллагаа юм. Даатгагч нь тодорхой төрлийн үйлчилгээ эрхлэхийн тулд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд энэ нь даатгалын баталгааг дур мэдэн, санхүүгийн чадваргүй этгээд гаргах эрсдэлийг хязгаарлахад чиглэгддэг. Иймд даатгалын баталгаа нь ердийн гэрээний харилцаа бус, харин төрийн хяналт, зөвшөөрлийн дор хэрэгжих зохицуулалттай санхүүгийн үйлчилгээ гэж үзэх үндэслэлтэй.

Энэхүү зөвшөөрөл олгох, хяналт тавих үндсэн чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг. Тус хороо нь даатгалын байгууллагад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос гадна тэдгээрийн санхүүгийн чадавх, төлбөрийн чадвар, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд байнгын хяналт тавьдаг. Энэ нь даатгагчийн гаргасан баталгаа бодитой, найдвартай байх, шаардлагатай тохиолдолд төлбөрийг гүйцэтгэх чадвартай байх нөхцөлийг хангахад чухал ач холбогдолтой юм.

Зөвшөөрөл олгох үйл явцад даатгагч нь тодорхой шалгуурыг хангах ёстой бөгөөд дүрмийн сангийн доод хэмжээ, санхүүгийн тогтвортой байдал, мэргэжлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын бодлого зэрэг багтана. Эдгээр шаардлага нь даатгалын баталгааны онцлогтой шууд холбоотой. Учир нь баталгаа гаргах нь өндөр дүнтэй, богино хугацаанд хэрэгжих санхүүгийн үүрэг үүсгэдэг тул даатгагч нь түргэн борлогдох хөрөнгөөр төлбөр гүйцэтгэх чадвартай байх шаардалагатай.

Хяналтын тогтолцооны хувьд СЗХ нь даатгагчийн үйл ажиллагаанд байнгын болон үе шаттай хяналт тавьдаг. Үүнд тайлагналын хяналт, газар дээрх шалгалт, эрсдэлийн үнэлгээ, санхүүгийн үзүүлэлтүүдийн хяналт зэрэг орно. Ялангуяа даатгалын баталгаатай холбоотойгоор даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 70 хувиас хэтрэхгүй байх хязгаарлалт тавьдаг нь нэг даатгагч дээр хэт их эрсдэл төвлөрхөөс сэргийлэх зорилготой.

Мөн ДтХ-ийн 6^1. 4-т зааснаар баталгааны дүн нь даатгагчийн эрсдэлийн сангаас даьсан тохиолдолд заавал давхар даатгалд хамрагдах үүрэг хүлээдэг бөгөөд энэ нь хяналтын механизмын нэг чухал хэсэг юм. Давхар даатгал нь зөвхөн эрсдэлийг

хуваарилах төдийгүй хяналтын байгууллагын зүгээс даатгагчийн эрсдэлийн удирдлагыг үнэлэх шалгуур болдог.

СЗХ-ооc баталсан багц дүрэм гэх зэрэг эрх зүйн актууд нь зөвшөөрөл олгох болон хяналт тавих үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг. Даатгалын баталгаа нь төрийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл, байнгын хяналтын тогтолцоонд суурилсан, өндөр хяналттай санхүүгийн үйлчилгээ юм. Энэ нь даатгалын баталгааг найдвартай, тогтвортой хэрэгсэл болгон ашиглах, улмаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг ханган үндсэн нөхцөл болж байна.

1.2.3. “Төрийн худалдан авах ажиллагаанд даатгалын баталгаа

Төрийн худалдан авах ажиллагаанд баталгааны хэрэгслийг ашиглах зохицуулалт нь даатгалын баталгааны практик хэрэглээг тодорхойлох гол эрх зүйн эх сурвалжийн нэг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд энэхүү харилцааг дэлгэрэнгүй зохицуулсан. Уг хуулийн хүрээнд тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа зэрэг үндсэн гурван төрлийн баталгааг зохицуулсан байна.

Тус хуулийн 14 дүгээр зүйлд зохицуулсан тендерийн баталгаа[22] нь тендерт оролцогчийн саналын үнэнч байдал, хариуцлагыг хангах зорилготой. Тодорхой үнийн дүнгээс дээш төсөвтэй тендерт оролцогч нь заавал баталгаа ирүүлэх үүрэгтэй бөгөөд уг баталгааг банк, Засгийн газрын үнэт цаас, эсхүл даатгагчийн баталгаагаар гаргах боломжтой гэж заасан нь даатгалын баталгааг банкны баталгаатай адил түвшинд хүлээн зөвшөөрч байгаа зохицуулалт юм. Мөн тендерээс татгалзах, гэрээ байгуулахаас зайлсхийх зэрэг нөхцөлд баталгааг улсын орлого болгох зохицуулалт нь баталгааны үүргийн гүйцэтгэлийг хангах батлан даалтын механизмыг харуулж байна.

Цаашлаад 42 дугаар зүйлд гүйцэтгэлийн баталгааг [23]зохицуулсан бөгөөд энэ нь гэрээ байгуулсны дараах шатанд гүйцэтгэгчийн үүргийн биелэлтийг хангах зорилготой. Гүйцэтгэлийн баталгааны дүнг тодорхой хувь хэмжээгээр тогтоож, мөн адил банк болон даатгагчийн баталгаагаар гаргахыг зөвшөөрсөн байгаа нь даатгалын баталгааг урт хугацааны гэрээний эрсдэлийг хуваалцах хэрэгсэл болгон ашиглаж байна. Энэ хүрээнд даатгагч нь зөвхөн анхны эрсдэлийг үнэлэхээс гадна гүйцэтгэлийн явцад үүсэх боломжит

[22] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2023), 14 дүгээр зүйлийн 14.1
[23] ТБОНӨХБАҮХтХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1

алдагдлыг тооцож, эрсдэлийн удирдлагын илүү нарийн механизм хэрэглэх шаардлагатай болдог.

Мөн 43 дугаар зүйлд урьдчилгаа төлбөрийн баталгааг [24]зохицуулсан бөгөөд энэ нь захиалагчийн урьдчилан олгосон хөрөнгийг хамгаалах зорилготой. урьдчилгаа төлбөрийг зөвхөн баталгаа гаргасан тохиолдолд олгох, баталгааны дүн нь урьдчилгаа төлбөрөөс багагүй байх шаардлага тавьсан нь санхүүгийн сахилга бат, эрсдэлийн хяналтыг өндөр түвшинд хангах зорилготой юм. Энэ төрлийн баталгаа нь даатгалын баталгааны хувьд хамгийн эрсдэлтэйд тооцогддог ба даатгагч нь гүйцэтгэгчийн санхүүгийн чадвар, төслийн хэрэгжилтийн магадлалыг өндөр нарийвчлалтай үнэлэх шаардлагатай болдог.

Тус хууль нь даатгалын баталгааг банкны баталгаатай ижил түвшинд авч үзэх замаар зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн төрийн худалдан авах ажиллагааны эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

[24] ТБОНӨХБАҮХтХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1

II БҮЛЭГ. ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ПРАКТИК АСУУДАЛ, ШИЙДЭЛ

2.1. Монголын даатгалын баталгааны зах зээл ба тулгамдсан асуудлууд

2.1.1. EPC/FIDIC гэрээний нөхцөл дэх даатгалын баталгаа

Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо буюу ФИДИК гэх нэршил нь Франц хэлээр Fédération Internationale des Ingénieurs-Conseils (FIDIC) гэх үгийн товчлол юм. Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо нь 1913 онд байгуулагдсан ба Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын хөгжлийн банкуудтай үйл ажиллагааны түвшинд хамтран ажиллаж, дэлхийд хэрэгжиж буй бүтээн байгуулалтын төслүүдэд мэргэжлийн сургалт, судалгаа болон зөвлөх үйлчилгээг нутагшуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ФИДИК-ийн Мөнгөлөн ном буюу “Condition of Contracts for EPC/Turnkey Projects” нь 1999 онд Улаан болон Шар номнуудын хамт Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны гэрээний багцийн гурав дахь загвар гэрээний загвар төрөл болон гарсан бөгөөд сүүлийн жилүүдэд томоохон хэмжээний барилгын төслүүдэд өргөнөөр хэрэглэх болсон.[25]

Гэрээний төрлийг сонгохдоо тухайн төслийн хэрэгцээ болон зураг төслийг хэн хариуцах вэ гэдэг дээр үндэслэдэг. Хэрэв Захиалагч өөрөө туршлагатай бол Улаан ном-ыг, харин үнэ болон хугацааны тодорхой байдлыг илүүд үзэж, эрсдэл багатай үед Мөнгөн ном-ыг сонгодог.

Бүх FIDIC гэрээнүүд нь талуудын үүрэг хариуцлагын тэнцвэртэй байдлыг хангаж, эрсдэлийг оновчтой хуваарилахыг зорьдог ба гэрээнүүд нь хоёр хэсгээс бүрдэнэ:

Гэрээний Ерөнхий нөхцөл (GCC): Бүх төсөлд нийтлэг хэрэглэгдэх үндсэн нөхцөлүүд.

Гэрээний Тусгай нөхцөл (PCC): Тухайн төслийн онцлогт тохируулан талуудын тохиролцсон нөхцөлүүд.[26]

EPC гэх үг нь:

“Инженерчлэл (Engineering): Гүйцэтгэгч тал төслийн нарийвчилсан төлөвлөлт болон зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бөгөөд ингэхдээ

[25] (Huse, J. A. (2009). Understanding and Negotiating Turnkey and EPC Contracts (2nd edition). Sweet & Maxwell. 5 дахь тал)
[26] Aceris Law LLC, цахим хуудас, https://www.acerislaw.com/fidic-contracts-overview-of-the-fidic-suite/

техникийн бүх үзүүлэлтүүд нь захиалагчийн шаардсан үйл ажиллагаа болон ашиглалтын гүйцэтгэлийн стандартад нийцэж буй эсэхийг хянаж баталгаажуулна.

Худалдан авалт (Procurement): Гүйцэтгэгч тал нь материалын эх үүсвэрийг тодорхойлох, гэрээ хэлцэл хийх, тоног төхөөрөмж болон туслан гүйцэтгэгчийн үйлчилгээг худалдан авах зэрэг нийтлэг хангамжийн үйл явцыг иж бүрнээр нь удирдана. Мөн төслийн тасралтгүй ажиллагааг хангах үүднээс нийлүүлэлтийн сүлжээний логистикийг зохицуулж, материалын тээвэрлэлтийг хугацаанд нь гүйцэтгэх үүргийг хүлээнэ.

Барилга (Construction): Гүйцэтгэгч тал нь барилга угсралтын үе шатыг ахлан чиглүүлж, талбайн үйл ажиллагаа болон нөөцийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Ингэснээр төслийг үр ашигтай, товлосон хугацаанд нь, чанар болон аюулгүй ажиллагааны стандартын дагуу гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ. гэх үгсийн товчлол бөгөөд гүйцэтгэгч талд энэ гурван үүргийг хуваариласан онцлогтой гэрээ юм.” гэх үгийн товчлол юм.[27]

Монголд даатгагч нар нь 2024 оны 08 дугаар сараас эхлэн баталгаа гаргаж эхэлсэн бөгөөд 2025 онд 10 даатгалын компани даатгалын баталгаа гаргаж, тайлант онд нийт 611.8 тэрбум төгрөгийн 1299 баталгаа гаргасан байна. [28]

Зураг 1.2 *Монгол улсын даатгалын баталгааны төрлүүдийн эзлэх хувь*

Баталгааны төрөл	Баталгааны тоо	Баталгааны дүнгийн эзлэх хувь
ТЕНДЕРИЙН БАТАЛГАА	941	5.7%
ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА	309	44.9%
УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА	42	49.2%
ЧАНАРЫН БАТАЛГАА	7	0.2%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, 2025

[27] FIDIC-ийн цахим хуудас, 2026 он, https://fidic.org
[28] СЗХ, “Зах зээлийн тойм” 2025 он

2.1.2. Олон улсын эрх зүйн зохицуулалт (EU, US Surety Bond law, UNCITRAL)

Улс орнуудын эрх зүйн тогтолцоо харилцан адилгүй боловч олон улсын худалдааны тогтвортой байдлыг хангах үүднээс нийтлэг зарчим, дүрэм, стандартууд хөгжсөн байдаг. Ялангуяа Европын Холбоо (EU), Америкийн Нэгдсэн Улсын surety bond system болон НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-ын боловсруулсан зохицуулалтууд нь өнөөгийн олон улсын баталгааны эрх зүйн үндсэн суурийг бүрдүүлж байна

Даатгалын баталгаа буюу surety bond, independent guarantee, performance guarantee зэрэг хэрэгслүүд нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, барилга байгууламж, төр-хувийн хэвшлийн түншлэл (PPP), төрийн худалдан авах ажиллагаанд өргөн хэрэглэгддэг санхүүгийн баталгааны механизм юм.

Улс орнуудын эрх зүйн тогтолцоо харилцан адилгүй боловч олон улсын худалдааны тогтвортой байдлыг хангах үүднээс нийтлэг зарчим, дүрэм, стандартууд хөгжсөн байдаг. Ялангуяа Европын Холбоо (EU), Америкийн Нэгдсэн Улсын даатгалын баталгааны систем болон НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-ын боловсруулсан зохицуулалтууд нь өнөөгийн олон улсын баталгааны эрх зүйн үндсэн суурийг бүрдүүлж байна

Европын Холбооны хэмжээнд даатгалын баталгааг тусгайлсан нэг хууль бус, харин даатгал, санхүүгийн үйлчилгээ, төрийн худалдан авах ажиллагааны ерөнхий зохицуулалтын хүрээнд авч үздэг. EU-ийн эрх зүйн баталгааны даатгал болон гүйцэтгэлийн баталгаа нь даатгалын бүтээгдэхүүний төрөлд хамаарах бөгөөд энэ хүрээнд даатгагч байгууллага нь санхүүгийн чадамж, эрсдэлийн удирдлага, хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангасан байх ёстой.[29] Энэ зохицуулалтын гол эх сурвалж нь Directive (EU) 2016/97 буюу Insurance Distribution Directive (IDD) юм. Уг удирдамжаар даатгалын бүтээгдэхүүн борлуулах болон зуучлах үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангах, эрсдэлийн мэдээллийг ил тод болгох үүргийг даатгагчид ногдуулсан байдаг.[30] Иймээс Европын орнуудад даатгалын баталгаа гаргахдаа тухайн даатгагчийн төлбөрийн чадвар, эрсдэл даах боломж, давхар даатгалын хамгаалалтыг заавал үнэлдэг онцлогтой.

Европын Холбооны даатгалын салбарын хамгийн чухал зохицуулалт бол Solvency II тогтолцоо юм. Энэхүү тогтолцоо нь даатгалын компаниудын хөрөнгийн хүрэлцээ,

[29] Directive (Eu) 2016/97 Of The European Parliament And Of The Council, 2016он
[30] European Parliament & Council of the European Union, 2016 он

эрсдэл даах чадвар, нөөц сангийн зохистой хэмжээг нарийвчлан тогтоодог. Даатгалын баталгаа гаргаж буй байгууллага нь даатгалын эрсдэл, харилцагчийн эрсдэл, эрсдэлийн төвлөрөл зэрэг эрсдэлийг үнэлэх үүрэгтэй бөгөөд тухайн баталгааны хэмжээ нь компанийн санхүүгийн бодит чадамжаас давсан тохиолдолд зохицуулагч байгууллагаас хязгаарлалт тавих боломжтой байдаг.[31] Энэ нь Монгол Улсад ажиглагдаж буй "хэт өндөр дүнтэй баталгаа гаргах", "давхар даатгалд хэт төвлөрүүлэх" зэрэг эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн Европын Холбооны төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн хүрээнд тендерийн болон гүйцэтгэлийн баталгааг өргөн хэрэглэдэг. Directive 2014/24/EU-ийн дагуу төрийн байгууллагаас шаардах баталгааны хэмжээ нь зах зээлийн бодит нөхцөл байдалтай нийцсэн, өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл төрийн байгууллага нь дотоодын даатгалын зах зээлийн нийт боломж, эрсдэл даах чадамжаас хэтэрсэн баталгаа шаардах нь шударга өрсөлдөөний зарчимд харшилна гэж үздэг.

Америкийн Нэгдсэн Улсад даатгалын баталгаа нь хамгийн өндөр хөгжсөн тогтолцоонд тооцогддог. АНУ-ын эрх зүйд даатгалын баталгаа нь гэрээний эрх зүй, даатгалын эрх зүй, арилжааны эрх зүйн огтлолцолд орших бөгөөд ихэвчлэн гурван талт харилцаанд тулгуурладаг. Үүнд principal буюу үндсэн үүрэг гүйцэтгэгч, obligee буюу баталгаа шаардагч, surety буюу баталгаа гаргагч оролцдог. Америкийн даатгалын баталгааны гол онцлог нь баталгаа гаргагчийн үүрэг нь үндсэн гэрээнээс хамааралтай дагалдах шинжтэй байдагт оршино.[32] Өөрөөр хэлбэл үндсэн үүрэг гүйцэтгэгч бодитоор гэрээг зөрчөөгүй тохиолдолд баталгаа гаргагч төлбөр хийх үүрэг хүлээдэггүй.

АНУ-ын холбооны хэмжээний хамгийн чухал зохицуулалт бол Miller Act юм. Энэхүү хуулиар холбооны төсвөөр хэрэгжүүлэх барилгын төслүүдэд гүйцэтгэлийн баталгаа болон төлбөрийн баталгаа заавал шаардана. Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний гүйцэтгэлийг хамгаалдаг бол төлбөрийн баталгаа нь туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчдийн төлбөрийг баталгаажуулдаг. Miller Act-ийн онцлог нь баталгаа шаардагч төлбөр шаардахын тулд үндсэн үүрэг гүйцэтгэгч гэрээ зөрчсөнийг нотлох шаардлагатай байдагт оршино. Иймээс АНУ-ын даатгалын баталгаа нь олон улсын худалдаанд хэрэглэгддэг шаардмагц төлөх баталгаанаас ялгаатай бөгөөд баталгаа гаргагч нь тодорхой хамгаалалт эдэлдэг.[33]

---

[31] Directive 2009/138/Ec Of The European Parliament And Of The Council, 2009 он
[32] Gallagher. R, Surety Bonds: Their Use and Misuse. *Construction Law Journal*, 2000 он
[33] Miller Act, 1935 он

Америкийн нийтлэг эрх зүйн тогтолцооны дагуу баталгаа нь үндсэн гэрээнээс салангид бие даасан үүрэг биш юм. Хэрэв үндсэн гэрээ хүчингүй болвол эсвэл баталгаа шаардагч өөрөө гэрээг зөрчсөн бол баталгаа гаргагч төлбөрөөс татгалзах боломжтой. Энэ нь банкны баталгаа болон олон улсын бие даасан баталгаанаас үндсэн ялгаатай.

Олон улсын хэмжээнд даатгалын баталгааны хамгийн нөлөө бүхий зохицуулалтын нэг нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс буюу UNCITRAL-аас боловсруулсан “Бие даасан баталгаа болон нөөц аккредитивын тухай конвенц”[34] юм. Энэхүү конвенц нь олон улсын худалдаанд хэрэглэгддэг бие даасан баталгаа болон нөөц аккредитивын нийтлэг дүрмийг тогтоосон бөгөөд олон улсын худалдааны эрх зүйн практикт томоохон нөлөө үзүүлсэн.

Тус конвенцийн хамгийн чухал зарчим нь бие даасан байдлын зарчим юм. Энэ зарчмын дагуу баталгаа нь үндсэн гэрээнээс тусдаа, бие даасан үүрэг гэж тооцогддог. Өөрөөр хэлбэл ашиг хүртэгч шаардлагатай баримт бичгийг гэрээнд заасан хэлбэрээр гаргаж өгсөн тохиолдолд баталгаа гаргагч төлбөр хийх үүрэгтэй бөгөөд үндсэн гэрээний маргаан, ажил гүйцэтгэлийн бодит нөхцөл байдал, гэрээний зөрчил байгаа эсэхийг шалгах эрхгүй байдаг. Энэ нь олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг шаардмагц төлөх баталгааны үндсэн шинж юм.

Гэсэн хэдий ч тус конвенц нь баталгаа гаргагчийг ашиг хүртэгчийн илт шударга бус шаардлагаас хамгаалах зорилгоор залилангийн онцгой тохиолдлыг зөвшөөрдөг. Хэрэв ашиг хүртэгч хуурамч баримт ашигласан, эсвэл илт шударга бус шаардлага гаргасан нь тогтоогдвол шүүх төлбөрийг түдгэлзүүлэх боломжтой. Энэ нь олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг “эхэлж төлөөд дараа нь марга” зарчмыг тодорхой хэмжээнд хязгаарлаж буй хэлбэр юм.

НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс болон Олон улсын худалдааны танхимаас боловсруулсан олон улсын дүрмүүд нь баримт бичгийн нийцлийн зарчимд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл баталгаа гаргагч нь зөвхөн баримт бичгийн гаднах хэлбэр, нийцлийг шалгах бөгөөд гэрээ бодитоор зөрчигдсөн эсэхийг шалгах үүрэггүй. Ялангуяа ICC-ийн Uniform Rules for Demand Guarantees (URDG 758) нь дэлхийн хэмжээнд шаардмагц төлөх баталгааны хамгийн өргөн хэрэглэгддэг дүрэм болсон. [35]URDG 758-ийн дагуу guarantor нь зөвхөн demand notice болон шаардлагатай баримт бичгийн нийцлийг шалгах бөгөөд үндсэн гэрээний маргаанд оролцох ёсгүй гэж үздэг.

[34] United Nations Convention on Independent Guarantees and Stand-by Letters of Credit, 1995 он
[35] International Chamber of Commerce, 2010 он

Ийнхүү олон улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзвэл АНУ-ын даатгалын баталгааны систем нь үндсэн гэрээнээс хамааралтай батлан даалтын шинжтэй байдаг бол UNCITRAL болон ICC URDG 758-д суурилсан Европ тивийн практикт бие даасан шаардмагц төлөх төлбөрийн тогтолцоог түлхүү хөгжүүлсэн байна.

2.1.3. Даатгалын синдикатыг өрсөлдөөний эрх зүйн үүднээс шинжилсэн

Даатгалын салбарт **“синдикат”** гэх ойлголт нь нэг даатгагч бие даан хариуцах боломжгүй хэт өндөр дүнтэй эрсдэлийг хэд хэдэн даатгалын компани хамтран хуваан хүлээх зохион байгуулалтын хэлбэр юм. Олон улсын практикт энэ нь томоохон дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, нисэх хүчин болон төрийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн баталгаа зэрэг онцгой эрсдэлтэй салбарт түгээмэл ашиглагддаг.

Синдикатын үндсэн зорилго нь:

- Эрсдэлийн төвлөрлийг сааруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
- Нэг компанид ирэх төлбөрийн чадварын дарамтыг бууруулах;
- Томоохон төслүүдийг дотоодын зах зээлийн нөөц бололцоонд тулгуурлан даатгах боломжийг бүрдүүлэхэд оршдог.

Өрсөлдөөний эрх зүйн үүднээс авч үзвэл, синдикат нь зах зээл дээрх өрсөлдөгч этгээдүүдийн хамтын ажиллагаа учраас “шударга өрсөлдөөний зарчимд нийцэх үү?” гэх асуултыг зайлшгүй дагуулдаг. Хэд хэдэн даатгагч нэгдэж, нэг ижил нөхцөл, ижил хураамжаар үйлчилгээ үзүүлэх нь **“картель”** шинжтэй зохион байгуулалт уу, эсвэл эдийн засгийн **“зайлшгүй хамтын ажиллагаа”** юу гэдгийг зааглах шаардлагатай.

Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлд аж ахуй эрхлэгчид хоорондоо үнэ тохиролцох, зах зээлийг хуваах, өрсөлдөөнийг хязгаарлах хэлцэл байгуулахыг хориглосон. Синдикатын хүрээнд даатгагчид хураамж, эрсдэлийн хувь хэмжээг урьдчилан тохиролцох нь формаль утгаараа **хэвтээ хэлцэл**д тооцогдох бөгөөд энэ нь өрсөлдөөний хяналтаас гадуур өнгөрөх боломжгүй асуудал юм.

Монгол шиг жижиг, төвлөрөл өндөртэй зах зээлд давамгай байр суурьтай оролцогчид синдикат байгуулах нь дараах эрсдэлийг дагуулдаг:

1. Зах зээлд нэвтрэх хүндрэл**:** Жижиг, дунд даатгагчдыг томоохон төслүүдээс шахах.
2. Уялдаа холбоотой үйл ажиллагаа (Concerted practice): Үнээр өрсөлдөх боломжийг үгүйсгэж, хураамжийг зохиомлоор тогтоох.

Өрсөлдөөний эрх зүй нь бүх төрлийн хамтын ажиллагааг шууд хориглодоггүй. Европын Холбооны практикт үүнийг **“Efficiency defense”** буюу эдийн засгийн үр ашигт үндэслэсэн зөвтгөлөөр тайлбарладаг. Хэрэв хамтын ажиллагаа нь:

- Хэрэглэгчид бодит үр ашиг авчирч байвал;
- Зах зээлд шинэ үйлчилгээг бий болгож байвал;
- Бие даан хэрэгжүүлэх боломжгүй эрсдэлийг удирдахад чиглэсэн бол өрсөлдөөнийг тодорхой хэмжээнд хязгаарлахыг зөвшөөрдөг.[36]

Даатгалын синдикат нь зах зээлийг хязгаарлах бус, харин зах зээлийн "хоосон орон зай"-г нөхөх механизм гэж тайлбарлагдаж болно. Гэвч энэ нь зөвхөн ил тод, ялгаваргүй байх зарчимд тулгуурлах ёстойг Европын Комиссоос (2010) анхааруулдаг.

Одоогийн байдлаар манай улсын хууль тогтоомжид даатгалын синдикатыг байгуулах журам, мэдээлэл солилцооны хязгаар, хяналтын механизм тодорхойгүй байна. Энэхүү эрх зүйн тодорхойгүй байдал нь эдийн засгийн хэрэгцээг хууль бус картель болгож харагдуулах, эсвэл эсрэгээрээ өрсөлдөөнийг бодитойгоор боомилох нөхцөлийг бүрдүүлж байна.

Цаашид анхаарах шалгуур үзүүлэлтүүд:

1. **Зайлшгүй байдал:** Нэг даатгагч тухайн эрсдэлийг дангаараа даах боломжгүйг нотлох.
2. **Хязгаарлагдмал хүрээ:** Синдикатыг зөвхөн тухайн төслийн хугацаа, хэмжээгээр хязгаарлах.
3. **Ил тод байдал:** Хураамж, нөхцөлийг өрсөлдөөний байгууллагад тайлагнадаг байх.
4. **Нээлттэй байдал:** Шинэ оролцогч (даатгагч) синдикат руу орох боломжийг ялгаваргүй хангасан байх.

Хэсгийн дүгнэлт: Даатгалын синдикат нь өөрөө “хууль бус” үзэгдэл биш. Харин үүнийг эдийн засгийн бодит шаардлагад нийцсэн, өрсөлдөөнийг хамгийн бага түвшинд хязгаарлах нөхцөлтэйгөөр зөвшөөрөх нь шударга өрсөлдөөний зарчимд нийцнэ. Монгол Улсын хувьд энэхүү харилцааг Өрсөлдөөний тухай хууль болон Даатгалын тухай

[36] European Commission, 2010 он

хуулиар нарийвчлан зохицуулж, өрсөлдөөний байгууллагын (МЭГ) урьдчилсан хяналтын үйл ажиллагааг нэвтрүүлэх нь зүйтэй.

2.1.4. Хэрэглэгчийн эрх ашиг: Банк ба даатгалын баталгаа

Бизнесийн үйл ажиллагаа, төрийн худалдан авах ажиллагаа, барилга байгууламж, уул уурхай болон томоохон төслүүдийн хүрээнд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор банкны баталгаа болон даатгалын баталгаа өргөн хэрэглэгддэг. Эдгээр нь аль аль нь үүргийн биелэлтийг баталгаажуулах санхүүгийн хэрэгсэл боловч эрх зүйн шинж, эрсдэлийн бүтэц, хэрэглэгчид үзүүлэх санхүүгийн дарамт, үйлчилгээний нөхцөл зэргээрээ ялгаатай байдаг. Иймээс хэрэглэгч буюу баталгаа гаргуулагчийн эрх ашигт аль хэлбэр нь илүү таатай нөхцөл бүрдүүлж буйг судлах нь чухал ач холбогдолтой юм.

Банкны баталгаа нь банкнаас харилцагчийн өмнөөс тодорхой үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж, үндсэн үүрэг биелээгүй тохиолдолд банкинд шууд төлбөрийн үүрэг үүсдэг санхүүгийн хэрэгсэл юм. Олон улсын практикт банкны баталгаа нь ихэвчлэн “шаардмагц төлөх” буюу on-demand шинжтэй байдаг бөгөөд ашиг хүртэгч шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн гаргасан нөхцөлд банк үндсэн гэрээний маргааныг үл харгалзан төлбөр хийх үүрэгтэй байдаг. Иймээс ашиг хүртэгчийн хувьд банкны баталгаа нь төлбөрийн найдвартай байдал өндөртэй, эрсдэл багатай хэрэгсэлд тооцогддог.

Харин даатгалын баталгаа нь даатгагч байгууллагаас гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулж буй хэлбэр бөгөөд даатгалын эрсдэлийн зарчимд тулгуурладгаараа онцлогтой. Даатгагч нь эрсдэлийг үнэлж, хураамж тооцон, тодорхой нөхцөл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгох үүрэг хүлээдэг. Иймээс даатгалын баталгаа нь банкны баталгаатай харьцуулахад илүү уян хатан, санхүүгийн дарамт багатай байх боломжтой гэж үздэг.

Хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс авч үзвэл банкны баталгааны хамгийн том сул тал нь өндөр хэмжээний барьцаа болон хөрөнгийн шаардлага байдаг. Банкууд ихэвчлэн баталгааны дүнтэй тэнцэх эсвэл түүнд ойролцоо хэмжээний барьцаа хөрөнгө, мөнгөн хадгаламж, үл хөдлөх хөрөнгө, эсвэл бусад санхүүгийн баталгаа шаарддаг. Энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд эргэлтийн хөрөнгийг түгжих, санхүүгийн дарамт үүсгэх, зээлжих чадварыг бууруулах эрсдэлтэй. Ялангуяа урт хугацааны төсөл хэрэгжүүлэгч компаниудын хувьд их хэмжээний хөрөнгө барьцаанд байршуулах нь үйл ажиллагааны хөрвөх чадварт сөргөөр нөлөөлдөг.

Үүний эсрэгээр даатгалын баталгаа нь ихэнх тохиолдолд банк шиг бүрэн хэмжээний барьцаа шаарддаггүй. Даатгагч байгууллага нь эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хураамж тооцдог тул хэрэглэгчийн хувьд хөрөнгийн шууд дарамт харьцангуй бага байдаг. Энэ нь ялангуяа жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд илүү таатай нөхцөл бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл хэрэглэгч нь эргэлтийн хөрөнгөө түгжихгүйгээр тендерт оролцох, гэрээ байгуулах, төслийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой байдаг.

Гэсэн хэдий ч даатгалын баталгааны сул тал нь төлбөрийн найдвартай байдал болон эрх зүйн тодорхой бус байдалтай холбоотой байж болно. Банкны баталгаа нь ихэвчлэн бие даасан “шаардмагц төлөх” шинжтэй байдаг бол даатгалын баталгаанд даатгалын нөхцөл, эрсдэлийн үнэлгээ, нөхөн төлбөрийн шалгалт зэрэг нэмэлт ажиллагаа ордог. Иймээс ашиг хүртэгчийн хувьд банкны баталгаа шиг шууд мөнгөн хөрвөх чадвар бий болохгүй байх эрсдэлтэй. Ялангуяа даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт тодорхой бус улс оронд нөхөн төлбөр олголт удаашрах, маргаан үүсэх, давхар даатгалын бодит хүчин чадал тодорхойгүй байх асуудал гарч болдог.

Монгол Улсын нөхцөлд хэрэглэгчдийн хувьд даатгалын баталгаа нь эдийн засгийн хувьд илүү хүртээмжтэй хэрэгсэл болж эхэлж байна. Учир нь дотоодын компаниуд өндөр дүнтэй банкны баталгаанд шаардагдах хэмжээний хөрөнгө барьцаалах боломжгүй байх тохиолдол түгээмэл байдаг. Энэ нөхцөлд даатгалын баталгаа нь бизнесийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, санхүүгийн хүртээмжийг өргөжүүлж буй эерэг талтай. Гэвч нөгөө талаас даатгалын компаниудын санхүүгийн чадамж, давхар даатгалын хамгаалалт, төлбөрийн бодит баталгаанд эргэлзээ үүсэх тохиолдол байгаа нь хэрэглэгчийн эрх ашгийг бүрэн хамгаалж чадах эсэх асуудлыг хөндөж байна.

Мөн хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс мэдээллийн ил тод байдал чухал асуудал болдог. Банкны баталгааны нөхцөл, төлбөрийн механизм олон улсын жишигт харьцангуй тогтсон байдаг бол даатгалын баталгааны нөхцөл нь компани бүрээс хамаарч өөр өөр байж болно. Үүнээс шалтгаалан хэрэглэгч баталгааны бодит хамрах хүрээ, нөхөн төлбөрийн нөхцөл, давхар даатгалын хамгаалалтын талаар бүрэн мэдээлэлгүйгээр гэрээ байгуулах эрсдэл үүсдэг. Энэ нь мэдээллийн тэгш бус байдал бий болгож, хэрэглэгчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой.

Ийнхүү банкны баталгаа болон даатгалын баталгааг хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс харьцуулан үзвэл банкны баталгаа нь ашиг хүртэгчийн хувьд илүү найдвартай,

шууд хэрэгжих чадвартай боловч баталгаа гаргуулагчид өндөр барьцаа, санхүүгийн дарамт үүсгэдэг сул талтай байна. Харин даатгалын баталгаа нь баталгаа гаргуулагчийн хувьд илүү уян хатан, санхүүгийн хүртээмжтэй нөхцөл олгодог боловч төлбөрийн найдвартай байдал, эрх зүйн тодорхой байдал, даатгагчийн бодит төлбөрийн чадвартай холбоотой эрсдэлийг агуулж байна. Тиймээс хэрэглэгчийн эрх ашгийг бодитоор хамгаалахын тулд даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт, санхүүгийн хяналт, мэдээллийн ил тод байдлыг илүү нарийвчлан боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

2.1.5. Хянан шалгагдаж буй маргааны дүн шинжилгээ

Туулын хурдны замын төсөл дээр 500 тэрбум төгрөгийн баталгааг 11 даатгалын компани гаргасан. Энэхүү маргаан дээр эргэлзээ төрүүлэхүйц асуудал дэвшүүлэн дүн шинжилгээ хийсэн.

1. СЗХ-ны дүгнэсэнээр 500 тэрбум төгрөгийн баталгааг дангаар гаргах нь "Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам"-ын 2.2-т заасан $ДБ = ДӨХ \times 70\%$ томьёогоор тооцвол "Мөнх даатгал"-ын өөрийн хөрөнгөөс хэд дахин давсан бодит зөрчилдөөнтэй юу?

Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргадаг “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралтад “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг зааж өгсөн байдаг. Тус журмын 2.2-т “Даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ нь даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнгийн 70 хувиас хэтрэхгүй бөгөөд дараах томьёогоор тооцно:

$$ДБ = ДӨХ \times 70\%$$

ДБ – даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ

ДӨХ – даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн (“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 2.3, 2.4, 2.5 дахь хэсэгт заасан өөрийн хөрөнгийн дүн)” гэж заасан. Хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 2.3-т “Ердийн даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгийн дүнгээс даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын болон нийт өр төлбөрийн дүнг хасаж, тусгай нөөц сангийн дүнг нэмэх замаар буюу дараах томьёогоор тооцно:

$$ДӨХ = ДНХ - ДОХШЗ - НӨТ + ТНС$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн);

ДОХШЗ – даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн);

НӨТ – нийт өр төлбөрийн дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүн);

ТНС – тусгай нөөц сангийн дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн тусгай нөөц сангийн дүн).” гэж зааснаар “Мөнх даатгал” ХХК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь 2025 оны санхүүгийн байдлын тайлангаас харахад даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн нь:

$$28383.14 - 1818.19 - 16115.82 + 14197.45 = 24646.58$$

Тиймээс баталгааны дээд хэмжээ нь: $24646.58 \times 70\% = 17252.606$ байна.

Тус тохиолдолд гаргасан бодит баталгаа: 500 тэрбум

Дээд хэмжээнээс хэтэрсэн байдал: 500,000/17252.606=28.98 дахин илүү дүнгээр гэрээ байгуулсан байна.

“Мөнх даатгал” ХХК-ийн 500 тэрбум төгрөгийн баталгаа нь СЗХ-ны “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 2.2-т заасан өөрийн хөрөнгийн дүнгийн 70%-иас хэтрэхгүй байх хязгаарлалтаас ойролцоогоор 29 дахин давсан байна. Энэ нь тухайн компани өөрийн хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлсэн нь тооцооллоор нотлогдож байна. Энэ нь СЗХ-ны албан ёсны дүгнэлт болох “500 тэрбум төгрөгийн даатгагчийн баталгааг нэг даатгалын компани дангаараа гаргах санхүүгийн болон төлбөрийн чадамжгүй” гэсэн мэдэгдэлтэй бүрэн нийцэж байна. Иймд уг баталгаа нь хуулийн дагуу өөрийн хөрөнгөөс давсан тул хүчин төгөлдөр бус байх магадлал өндөр байна гэж үзэх үндэслэлтэй.

2. Даатгалын тухай хуулийн 6[1].4-т заасан даатгалын нөөц сангийн дүнгээс хэтэрсэн баталгааг заавал давхар даатгалд хамрагдах ёстой гэсэн заалт биелэгдэж, 91% (538.5 тэрбум) эрсдэл гадагш шилжсэн нь бодит эрсдэлийн удирдлага мөн үү, эсвэл зөвхөн хуулийн формаль биелэлт үү?

Даатгалын тухай хуулийн 6[1].4-т “Даатгагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гаргах баталгааны

үнийн дүн даатгалын нөөц сангийн энэ хуулийн 6[1].1-д заасан баталгаанд хамаарах эрсдэлийн сангаас хэтэрсэн бол давхар даатгалд хамрагдаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байхыг шаардана.” гэж заасан. Үүний дагуу даатгалын компаниуд нь өөрийн нөөц сангийн хязгаараас хэтэрсэн баталгаа гаргахдаа заавал давхар даатгалд хамрагдах ёстой гэсэн заавал биелүүлэх шаардлагыг тавьж байгаа нь даатгалын компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилготой эрсдэлийн зохицуулалт байна.

Хүснэгт 1.2 *Тооцоолол*

Үзүүлэлт	Дүн (Тэрбум ₮)	Хувь
Нийт баталгааны дүн	589.7₮	100%
Давхар даатгалд шилжүүлсэн дүн	538.5₮	91%
Цэвэр дотоод үлдэгдэл дүн	51.2₮	9%

Туулын хурдны замын төслийн хүрээнд 589.7 тэрбум төгрөгийн баталгааны 91% буюу 538.5 тэрбум төгрөгийг давхар даатгалд шилжүүлсэн нь дээрх 6[1].4-дэх заалтын формаль шаардлагыг хангаж буй мэт харагдаж байна. Өөрөөр дотоодын даатгалын компаниуд ойролцоогоор 9 %-ийн эрсдэлийг өөр дээрээ авч, үлдсэн хэсгийг гадаадын даатгалын зах зээлд шилжүүлсэн нь онолын хувьд том дүнтэй эрсдэлийг тараан байршуулж, санхүүгийн дарамтыг бууруулах зөв үйл ажиллагаанд тооцогддог.

Гэвч уг нөхцөл байдлыг илүү гүнзгий авч үзвэл энэ нь бодит эрсдэлийн удирдлага мөн эсэхэд эргэлзээ үүсэх хэд хэдэн үндэслэл байна:

1. Давхар даатгалд шилжүүлэн эрсдэлийг хүлээн авсан гадаад даатгагч байгууллагын санхүүгийн чадамж, зээлжих зэрэглэл, бодит төлбөрийн чадварын талаарх мэдээлэл тодорхой бус байгаа нь эрсдэлийг үнэхээр шилжүүлсэн эсэхийг баттай дүгнэх боломжийг хязгаарлаж байна. Хэрэв давхар даатгагч өөрөө хангалттай санхүүгийн чадамжгүй бол эрсдэл бодит байдал дээр буурахгүй, зөвхөн бичиг баримт гэрээний түвшинд шилжсэн хэлбэртэй болж үлдэж байна. мэргэжлийн давхар

2. Даатгалын онолын дагуу эрсдэлийг шилжүүлэх нь түүнийг “тархаан байршуулах” зорилготой байдаг. Гэвч энэ тохиолдолд эрсдэлийг хүлээн авсан этгээд “Jianbang Engineering Performance Guarantee (Shandong) Co.Ltd.” (“Жианбанг Инженеринг Перформанс Гаранти (Шаньдунг)” ХХК)” нь мэргэжлийн давхар даатгагч

бус, харин барилгын салбарын аж ахуйн нэгж байгаа нь эрсдэлийг бууруулсан бус, зөвхөн байршлыг нь шилжүүлсэн явдал юм.

3. Захиалагч тендерийн үйл ажиллагаанд "Мөнх даатгал"-ын санхүү, төлбөрийн чадамжийг СЗХ-ноос лавлах ба хянах үүргээ гүйцэтгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийг зөрчсөн үү, хариуцлага хэнд ногдох вэ?

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн агуулгыг бүхэлд нь авч үзвэл захиалагч нь тендер шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, гаргасан шийдвэр нь хуульд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, мөн оролцогчийн ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцах нийтлэг буюу ерөнхий үүрэг хүлээдэг. Гэвч уг тохиолдолд зохицуулагч байгууллагаас заавал лавлагаа авч, даатгалын компанийн төлбөрийн чадварыг тусгайлан баталгаажуулах ётой гэсэн шууд шаардлага тусгаагүй тул зөвхөн “Мөнх даатгал” ХХК-ийн санхүү, төлбөрийн чадамжийг СЗХ-оос лавлаж баталгаажуулаагүй гэх үндэслэлээр захиалагчийг 48 дугаар зүйлийг шууд зөрчсөн гэх хууль зүйн үндэслэл нь хангалтгүй юм.

Хэрэв “Мөнх даатгал” ХХК-ийн санхүүгийн чадамж сул байсан нь тухайн үед ил тод мэдээллээр тогтоогдох боломжтой, эсхүл тендерт ирүүлсэн материалд зөрчилтэй, эргэлзээтэй нөхцөл байдал ажиглагдаж байсан атлаа захиалагч нэмэлт нягталгаа хийгээгүй бол энэ нь ТБОНӨХБАҮХтХ-ийн 48.2.3-т заасан үнэлгээний хорооны зөвлөмжид хяналт тавих үүрэг, мөн 48.2.9-д заасан мэдээллийн үнэн зөвийг хариуцах үүргийг зохих ёсоор хэрэгжүүлээгүйд тооцно. Өөрөөр СЗХ-оос лавлагаа аваагүй үйлдэл нь өөрөө зөрчил биш боловч бодит эрсдэлийг үл тоомсорлосон ба уг заалтуудын агуулгаар “хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй эс үйлдэхүй” болон үнэлэгдэх боломжтой. Ялангуяа 500 тэрбум төгрөг гэдэг бол улсын төсвийн үлэмж хэсэг тул захиалагчаас шаардагдах хариуцлага нь ердийн үеийнхээс харьцангуй өндөр байх ёстой бөгөөд ийм хэмжээний үнийн дүнтэй тендерт лавлагаа аваагүйг ноцтой хайнга байдал гэж тодорхойлох үндэслэлтэй байна.

Нөгөө талаар, тус хуулийн 54.6-д аж ахуй эрхлэгчийн туршлага, гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулах зохицуулалт бий бөгөөд хэрэв тухайн тохиолдолд даатгалын компанийн чадавх нь ийм баталгаажуулалт шаардлагатай мэдээлэлд хамаарч байсан бол зохицуулагч

байгууллагатай уялдуулан шалгах шаардлага үүснэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй бол захиалагчийн зүгээс хяналтын ажиллагааг дутуу хэрэгжүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Хариуцлагын тухайд 48.3-т зааснаар захиалагч өөрийн эрх, үүргийг бусдад шилжүүлсэн ч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй тул үндсэн хариуцлага захиалагчид ногдоно. Үнэлгээний хороо буруу дүгнэлт гаргасан бол тэд хамтын хариуцлага хүлээх боловч эцсийн шийдвэр гаргасан этгээдийн хувьд захиалагч голлон хариуцлага хүлээнэ. Харин "Мөнх даатгал" ХХК нь өөрийн санхүүгийн байдлыг буруу, хэтрүүлсэн, эсхүл худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдвол тэд өөрсдөө шууд хууль зөрчсөнд тооцогдож, тендерийн эрх хязгаарлуулах, иргэний болон шаардлагатай тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлтэй болно. СЗХ-ны хувьд тендер тус бүр дээр лавлагаа өгөх идэвхитэй үүрэг хуулиар хүлээгээгүй тул шууд хариуцлага хүлээхгүй, харин зөвхөн өөрийн зохицуулалтын чиг үүргийн хүрээнд асуудал яригдана.

Иймээс дүгнэж хэлбэл, СЗХ-ноос лавлагаа аваагүй үйлдэл дангаараа 48 дугаар зүйлийн зөрчил биш боловч хэрэв бодит эрсдэлийг мэдэх боломжтой байсан нөхцөлд захиалагч нэмэлт шалгалт, нягталгаа хийгээгүй бол энэ нь хуулиар хүлээсэн хяналтын үүргээ биелүүлээгүйд тооцогдож, зөрчилд хүргэх бөгөөд уг тохиолдолд үндсэн хариуцлага захиалагчид, нөхцөлөөс хамааран үнэлгээний хороо болон оролцогч этгээдэд давхар ногдох эрх зүйн үндэслэл бүрдэнэ.

4. Жианбанг Инженеринг ХХК (Jianbang Engineering Co. Ltd) - ийн нэрийн өмнөөс "Мөнх даатгал" ХХК төлөөлөл болон оролцсон нь даатгалын тухай хуулийн дагуу зөвшөөрөгдөх үйл ажиллагаа бөгөөд энэ нь "даатгагч" эсвэл "брокер"-ын үүргийг биелүүлж байна уу?

Жианбанг Инженеринг ХХК-ийн нэрийн өмнөөс "Мөнх даатгал" ХХК төлөөлөн оролцсон асуудлыг эрх зүйн үүднээс зөв тодорхойлохын тулд юуны өмнө тухайн этгээдийн оролцож буй "эрх зүйн статус"-ыг ялгаж салгах шаардлагатай. Мөнх даатгал нь Даатгалын тухай хуулийн дагуу даатгагч статустай этгээд бөгөөд тусгай зөвшөөрлийхөө хүрээнд даатгалын гэрээ байгуулах, баталгаа гаргах, эрсдэлийг өөр дээрээ авах эрхтэй. Харин "даатгалын брокер" гэдэг нь тусдаа зөвшөөрлийн үндсэн дээр даатгагч болон даатгуулагчийг холбох, зуучлах үүрэг хүлээдэг, өөрөө эрсдэл хүлээдэггүй этгээд байдаг. Эрх зүйн зарчмын хувьд нэг аж ахуйн нэгж эрсдэл хүлээгч "даатгагч" болон "брокер"-ын үүргийг нэгэн зэрэг, холимог байдлаар гүйцэтгэх нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх тул хууль зүйн хувьд эрс ялгаатай зохицуулагддаг.

Хэрэв “Мөнх даатгал” ХХК өөрийн нэр дээр даатгалын баталгаа гаргаж, захиалагчийн өмнө хариуцлага хүлээсэн бол энэ нь даатгагчийн үндсэн үйл ажиллагаанд хамаарна. Өөрөөр хэлбэл, тендерт оролцогч этгээд гэрээний үүргээ биелүүлэхгүй тохиолдолд баталгаанд заасан төлбөрийг “Мөнх даатгал” ХХК өөрөө төлөх үүрэгтэй болж байгаа гэсэн үг. Энэ тохиолдолд эрсдэл анхдагчаар Монгол Улсад тусгай зөвшөөрөлтэй даатгагч дээр төвлөрч байгаа учраас эрх зүйн хувьд “баталгаа гаргасан даатгагч” гэж үзнэ. Харин цааш тухайн эрсдэлийн тодорхой хэсгийг давхар даатгалын гэрээгээр гадаадын компанид шилжүүлсэн байсан ч энэ нь дотоодын даатгагчийн үндсэн үүргийг өөрчлөхгүй. Учир нь захиалагчийн өмнө хариуцлага хүлээж буй этгээд нь хэвээрээ “Мөнх даатгал” ХХК байна. Иймээс энэ хэлбэр нь даатгалын үйл ажиллагааны хүрээнд хуульд нийцсэн бүтэц гэж тайлбарлагдана.

Гэвч энэ тохиолдолд “Мөнх даатгал” ХХК өөрөө бодитоор эрсдэл хүлээгээгүй, зөвхөн “Жианбанг Инженеринг” гэх гадаадын байгууллагыг захиалагчтай холбож өгсөн, эсвэл гадаад этгээдийн өмнөөс баримт бичиг дамжуулах, харилцаа зуучлах үүрэг гүйцэтгэсэн бол энэ нь агуулгын хувьд брокерийн шинжтэй үйл ажиллагаа болж хувирна. Өөрөөр хэлбэл, компани өөрөө баталгаа гаргагч биш, харин гуравдагч этгээдийн бүтээгдэхүүнийг зах зээлд холбон зуучлагчийн үүрэгтэй оролцсон гэсэн үг.

Гадаадын томоохон гүйцэтгэгчийг дотоодын даатгагчаар дамжуулан тендерт оролцуулах нь нэг талаас дотоодын зах зээлийг хамгаалах, зохицуулалтын хяналтыг хадгалах эерэг талтай ч, нөгөө талаас хэрэв дотоод даатгагчид бодит эрсдэлийг даах санхүүгийн чадамжгүй атлаа зөвхөн “дамжуулах” үүрэг гүйцэтгэж байвал зах зээлд хиймэл зуучлал, формаль даатгалын бүтэц бий болох эрсдэлтэй. Энэ нь даатгалын салбарын бодит чадавхыг гажуудуулж, эрсдэлийн бодит үнэлгээ бус, харин гэрээний формаль бүтцээр асуудлыг шийдэх сөрөг хандлагыг ыий болгоно.

Уг тохиолдолд хуульд нийцсэн эсэх нь хэлбэрээсээ бус, эрсдэлийн бодит шилжилт хийгдсэн эсэхээс хамаарна. Хэрэв “Мөнх даатгал” ХХК өөрөө баталгаа гаргаж, эрсдэлийг бие даан хүлээсэн бол энэ нь даатгагчийн хууль ёсны үйл ажиллагаа, харин зөвхөн гадаад этгээдийн өмнөөс төлөөлөн зуучилсан бол энэ нь зөвшөөрөлгүйгээр брокерийн үйл ажиллагаа эрхэлсэн зөрчил болон үнэлэгдэх боломжтой юм.

5. Тендерийн баримт бичигт 500 тэрбум төгрөгийн хэмжээтэй даатгалын баталгаа шаардахдаа Монголын даатгалын зах зээлийн бодит санхүүгийн хүчин чадал, эрсдэл даах боломжийг урьдчилан үнэлсэн эсэх, уг шаардлага нь зах зээлийн нийт боломжийн дийлэнх хэсгийг дангаар нь шаардсан хэт өндөр босго байсан уу, эсхүл

өрсөлдөөнийг хязгаарлаж тодорхой оролцогчид давуу нөхцөл бүрдүүлэх зорилготойгоор тогтоогдсон уу?

Тендерийн нөхцөлд 500 тэрбум төгрөгийн баталгааны шаардлагыг Монгол Улсын даатгалын салбарын санхүүгийн чадавхтай харьцуулахад анхнаасаа “биелэгдэх боломжгүй” шаардлага байсан эсэх, эсвэл “тодорхой этгээдэд давуу тал олгох” зорилготой байсан эсэх асуудал нь судалгааны гол зангилаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь зарчим нь тендерийн шаардлага нь зорилготойгоо нийцсэн, өрсөлдөөнийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй, оролцогчдод тэгш боломж олгосон байхаар зохицуулагдсан. Энэ хүрээнд баталгааны хэмжээ нь тухайн гэрээний үнийн дүн болон эрсдэлийн шинж чанартай харьцаа тэнцүү байх ёстой. Зах зээлийн бодит нөхцөлөөс хэт тасарсан шаардлага тавихыг хууль зүйн хувьд зохисгүйд тооцох үндэслэл бүрддэг.

Туулын хурдны зам төслийн урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргасан гэх “Jianbang Engineering Performance Guarantee (Shandong) Co., Ltd.” компанийн түүх болон бүртгэлийн мэдээлэл нь санхүүгийн салбарт байж болох хамгийн ноцтой эрсдэлүүдийг нэг дор харуулж байна. Анх 2021 онд ердөө 66 мянган юанийн дүрмийн сантай, жижиг худалдааны чиглэлээр байгуулагдсан энэхүү компани 2024 оны зургаадугаар сард гэнэтхэн нэрээ сольж, үйл ажиллагаагаа батлан даалтын чиглэл рүү хөрвүүлэн, капиталын хэмжээгээ 1.7 тэрбум юань болгон “цаасан дээр” огцом өсгөсөн нь олон улсын тендерт шалгарч, санхүүгийн чадамжтай мэт харагдах зорилготой байсныг илтгэж байна. Хамгийн сэжигтэй нь, 2025 оны сүүлээр энэхүү асар их капиталынхаа 99 хувийг бууруулж, ердөө 3 сая юань болгосон нь баталгаа гаргасан төслийнхөө өмнө санхүүгийн хариуцлага хүлээх чадваргүй болсныг нь баталж байгаа юм.

Компанийн дотоод бүтэц рүү өнгийж үзвэл, олон зуун тэрбум төгрөгөөр хэмжигдэх төсөлд баталгаа гаргаж буй байгууллага гэхэд нэг ч албан ёсны ажилтан байхгүй, программ хангамжийн салбарт бүртгэлтэй хэвээр байгаа нь энэ бол бодит үйл ажиллагаагүй, зөвхөн “shell company” буюу хиймэл бүрхүүл төдий байгууллага болохыг харуулж байна. Хятадын санхүүгийн хатуу зохицуулалтаас гадуур ийм төрлийн жижиг компаниуд үйл ажиллагаа явуулж, төрийн томоохон төслүүдийн урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргаж байгаа нь манай улсын холбогдох байгууллагууд гүйцэтгэгч болон батлан даагч талд тавих хяналт шалгалтаа (Due Diligence) хангалтгүй хийсэн, эсвэл санаатайгаар ийм эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэсэн байж болзошгүй гэх хардлагыг

төрүүлж байна. Ийм компаниар батлан даалгасан төслийн урьдчилгаа төлбөр эрсдэлд орвол түүнийг эргүүлэн төлүүлэх хууль зүйн болон санхүүгийн боломж бараг үгүй юм.

2.1.6. Гадаадын орнуудын даатгалын баталгааны эрх зүйн орчны харьцуулсан судалгаа

Өндөр хөгжилтэй орнуудад даатгалын баталгаа нь гэрээний үүргийн биелэлтийг хангах, бизнесийн эрсдэлийг бууруулах, төрийн худалдан авах ажиллагааны найдвартай байдлыг хангах чухал хэрэгсэл болж хөгжсөн байдаг.

Казахстан улсын даатгалын баталгааны талаархи хууль, эрх зүйн зохицуулалтууд

Казахстан улс нь Төв Азийн бүс нутагтаа санхүү, даатгалын салбарын эрх зүйн шинэчлэл, технологийн дэвшлээрээ тэргүүлж буй орнуудын нэг юм. Тус улсын даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалт, шинэчлэлийн үр нөлөө болон өнөөгийн сул талуудыг авч үзсэн. Казахстан Улс нь Дундад Азийн хамгийн томоохон санхүүгийн зах зээлтэй улсуудын нэг бөгөөд даатгалын салбарыг хамгаалах тогтолцоог 2003 оноос эхлэн хөгжүүлж ирсэн. Казахстаны даатгалын баталгааны эрх зүйн орчин нь олон давхаргат хуульчилсан зохицуулалтаас бүрддэг.

Даатгалын компаниуд баталгаа гаргахдаа мөрдөх санхүүгийн норматив, эрсдэлийн сангийн хэмжээг СЗХ-той адил чиг үүрэг бүхий Казахстаны Санхүүгийн зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх агентлаг (АРРФР)-аас баталсан журмаар зохицуулна.

Үндсэн хуульчилсан эрх зүйн баримт бичгүүд

Үүргийн гүйцэтгэлийг хангах хэлбэр: Иргэний хуулийн заалтаар даатгалын баталгааг “Батлан даалт” (Поручительство) болон “Баталгаа” (Гарантия)-ны холимог шинж чанартай, үүргийн гүйцэтгэлийг хангах бие даасан санхүүгийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрдөг.

Гуравдагч этгээдийн ашиг сонирхол: Иргэний хуулийн 803-845 дугаар зүйлд Даатгалын гэрээний ерөнхий зохицуулалтыг тусгасан. Баталгааны даатгал нь даатгуулагч (үүрэг гүйцэтгэгч) болон даатгагч хоёрын хооронд байгуулагддаг ч хохирол арилгах төлбөрийг зөвхөн ашиг хүртэгч буюу гуравдагч этгээд (үүрэг гүйцэтгүүлэгч/захиалагч)-д олгох эрх зүйн нөхцөлийг энэ хуулиар хамгаалдаг.

- **“Даатгалын төлбөрийг баталгаажуулах сангийн тухай” хууль (2003.06.03, № 423-II)**

  Энэ хууль нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын байгууллага дампуурах үед нөхөн төлбөрийн тогтолцоог хэрэгжүүлэх зорилготой. Өөрөөр

хэлбэл даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах “хамгаалалтын сүлжээ”-ний үндсэн эрх зүйн эх сурвалж болдог.

- **“Даатгалын үйл ажиллагааны тухай” хууль (2000.12.18, № 126-II)** Даатгалын байгууллагын лиценз олголт, төлбөрийн чадварын шаардлага, нөөц сан бүрдүүлэлт, эрсдэлийн удирдлага, хяналт шалгалтын тогтолцоог бүхэлд нь зохицуулдаг суурь хууль юм. Даатгалын баталгаа гаргах эрх зүйн үндэс энэ хуулиар бүрддэг.

Нийгмийн хамгийн эрсдэлтэй 3 салбарыг хамгаалсан хууль:

- **“Тээврийн хэрэгслийн эзэмшигчдийн иргэний хариуцлагын заавал даатгалын тухай” хууль (2003.07.01, № 446-II)** Зам тээврийн ослын эрсдэлийг даатгалын системээр зохицуулах зорилготой бөгөөд гуравдагч этгээдийн хохирлыг нөхөн төлөх баталгааны механизмыг бий болгосон.
- **“Аяллын (зорчигчийн) заавал даатгалын тухай” хууль (2003.12.31, № 513-II)** Зорчигч тээврийн үйлчилгээний явцад үүсэх эрсдэлийг даатгалын хэлбэрээр хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тогтоосон.
- **“Ажилтны хөдөлмөрийн ослын даатгалын тухай” хууль (2005.02.07)** Хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдсанаас үүдэлтэй осол, гэмтэл, нас баралтын эрсдэлийг даатгалын системээр нөхөн төлөх зохицуулалтыг тогтоодог.

Мөн сүүлийн жилүүдэд Казахстан Улс даатгалын салбарыг олон улсын стандарттай нийцүүлэх зорилгоор дараах шинэчлэлүүдийг хийсэн:

- **2022 оны 7 дугаар сарын 12-ны № 138-VII хууль** – даатгалын зах зээлийн зохицуулалтыг сайжруулж, эрсдэлийн удирдлагын шаардлагыг чангатгасан. Даатгалын компаниуд хэтэрхий их дүнтэй “Даатгалын баталгаа” гаргаад, тэр нь нурвал өөрсдөө хамт дампуурах аюултай. Энэ хуулиар компаниудыг эрсдэлээ маш нарийн тооцож, цахим системд бүртгэхийг шаардсан. Ингэснээр даатгалын баталгаа хуурамчаар үйлдэгдэх, эсвэл мөнгөгүй баталгаа гарах эрсдэлгүй болсон.[37]
- **2021 оны 1 дүгээр сарын 2-ны № 399-VI хууль** – гадаадын даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчилсан. Казахстаны дотоодын компаниуд тэрбум

[37] Republic of Kazakhstan. Law No. 138-VII, 2022 он

> тэрбумын дүнтэй том төслүүдэд баталгаа гаргаж чадахгүй мөнгө нь дутдаг байв. Гадаадын дэлхийн хэмжээний том даатгагчдын салбарыг орж ирэх хуулийг нээснээр, том төслүүд санхүүгийн найдвартай баталгаатай болох боломж бүрдсэн.[38]

Эдгээр хуулиуд нь даатгалын баталгааны тогтолцоог зөвхөн иргэний эрх зүйн хүрээнд бус, санхүүгийн хяналт, зах зээлийн тогтвортой байдал, хэрэглэгчийн эрх хамгаалалтыг хамарсан цогц систем болгон хөгжүүлж байна.

Казахстаны Иргэний хууль (Гражданский кодекс РК) нь даатгалын баталгааны эрх зүйн үндсийг хамгийн суурь түвшинд тодорхойлсон баримт бичиг бөгөөд уг хууль нь 1994 оны Ерөнхий анги, 1999 оны Тусгай анги гэсэн хоёр үндсэн бүтэцтэй. Даатгалын баталгааны харилцааг Иргэний хуульд хоёр үндсэн чиглэлээр уялдуулан зохицуулсан байдаг. Үүнд: (i) үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүйн хэрэгсэл, (ii) даатгалын гэрээний тусгай зохицуулалт юм.

Үүргийн гүйцэтгэлийн хангах арга буюу ерөнхий анги

Казахстаны Иргэний хуулийн 18 дугаар бүлэгт үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудыг заасан байдаг. Үүнд даатгалын баталгааг шууд утгаар нь биш, харин түүний эрх зүйн мөн чанарыг дараах хоёр хэлбэрээр уялдуулан зохицуулдаг:

- **Батлан даалт (Поручительство) ба Баталгаа (Гарантия):** Иргэний хуулийн 329–336 дугаар зүйлд баталгаа гаргагч нь үүрэг гүйцэтгэгчийн (төсөл хэрэгжүүлэгчийн) өмнөөс үүрэг гүйцэтгүүлэгчийн (захиалагчийн) өмнө хариуцлага хүлээх харилцааг заасан.[39]
- Даатгалын компаниуд баталгаа гаргахдаа Иргэний хуулийн энэхүү "Баталгаа"-ны суурь зарчмыг удирдлага болгодог бөгөөд үүрэг гүйцэтгэгч гэрээгээ зөрчвөл даатгагч хариуцлагыг хүлээдэг.

Даатгалын гэрээний тусгай зохицуулалт

ИХ-ийн 40-р бүлэг (803-845 дугаар зүйл) нь даатгалын харилцааг тусгайлан зохицуулдаг бөгөөд даатгалын баталгааны эрх зүйн үндсэн зохицуулалт энэ бүлэгт илүү нарийвчлан

[38] Republic of Kazakhstan. Law No. 399-VI, 2021 он

[39] Civil Code of the Republic of Kazakhstan, 1994 он

зохицуулагдсан байдаг. Энэ хэсэгт баталгааны даатгалд шууд хамаарах дараах чухал хэм хэмжээнүүд тусгагдсан:[40]

А. Гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах (815 дугаар зүйл)

Хуулийн дагуу баталгааны даатгалын гэрээг үүрэг гүйцэтгэгч өөрөө байгуулж, хураамжийг төлдөг ч, даатгалын нөхөн олговрыг (баталгааны мөнгө) авах эрхтэй "Ашиг хүртэгч" (Выгодоприобретатель) нь зөвхөн захиалагч тал (төрийн байгууллагч эсвэл үүрэг гүйцэтгүүлэгч) байна гэж заасан. Захиалагч нь гэрээ байгуулахад биечлэн оролцоогүй ч хуулиар нөхөн төлбөр шаардах бүрэн эрхтэй.

Б. Даатгалын тохиолдол ба Хуулийн хариуцлага (817 дугаар зүйл)

Үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл зохихсоор биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйг **"Даатгалын тохиолдол"** гэж үзнэ. Иргэний хуулиар даатгалын тохиолдол бий болсон үед даатгагч хохирлыг маргаангүй хугацаанд төлөх үүрэг хүлээдэг.

В. Суброгаци буюу Эргэх шаардлага гаргах эрх (840 дүгээр зүйл)

Энэ нь даатгалын баталгааны хамгийн чухал зохицуулалт юм.

Зарчим: Даатгалын компани үүрэг гүйцэтгэгчийн алдаанаас болж захиалагчид баталгааны төлбөрийг олгосон бол, уг олгосон мөнгөн дүнг **буруутай этгээдээс (үүрэг гүйцэтгэгчээс) эргүүлэн нэхэмжилж, өөртөө татах** (Регресс / Суброгаци) эрхийг Иргэний хуулиар шууд олгодог.

Казахстаны Иргэний хуулийн 152 дугаар зүйлд (Хэлцлийн хэлбэр) сүүлийн жилүүдэд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр цахим хэлбэрээр хийсэн хэлцлийг бичгээр хийсэн хэлцэлтэй ижил түвшинд үзэхээр заасан.

- Үүний дагуу Иргэний хуулийн 825 дүгээр зүйлд **цахим хэлбэрээр даатгалын гэрээ (полис) байгуулах**харилцааг хуульчилсан. Даатгалын баталгааг цахим системээр олгож, цахим гарын үсгээр баталгаажуулах эрх зүйн гол тулгуур нь Иргэний хуулийн энэ заалт болдог байна.

Хэсгийн дүгнэлт: Казахстан улсын Иргэний хууль нь даатгалын баталгааг **"Үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа"** болон **"Гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөөх даатгал"** гэсэн хоёр ухагдахууныг эрх зүйн хувьд маш сайн уялдуулж, даатгагч

[40] Civil Code of the Republic of Kazakhstan, 1999 он

төлбөрөө хийсний дараа буруутай этгээдээс мөнгөө заавал эргүүлж авах эрхийг нь тодорхой хамгаалж өгсөн байдгаараа онцлогтой.

2. Эрх Зүйн Шинэчлэлийн Үр Нөлөө

Сүүлийн жилүүдэд (ялангуяа 2021, 2022 оны хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээр) хийгдсэн реформууд нь дараах эерэг үр дүнгүүдийг авчирчээ.

А. Төрийн худалдан авах ажиллагааны цахимжуулалт

Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн систем (Goszakup) нь даатгалын компаниудын системтэй шууд холбогдсон байдаг. Баталгааг цахим дижитал гарын үсэг болон QR кодоор баталгаажуулдаг тул хуурамчаар үйлдэх эрсдэлийг бүрэн устгасан.

Б. Даатгалын Омбудсмений институт

Хуулийн шинэчлэлээр маргааныг шүүхээс өмнө Омбудсменээр заавал шийдвэрлүүлэх заалт оруулсан. Ингэснээр даатгалын компаниуд төлбөр олгохоос шалтгаангүйгээр татгалзах, хугацаа сунгах маргаан эрс багассан.

В. Даатгалын төлбөрийг баталгаажуулах сан/Фонд гарантирования страховых выплат (ФГСП)

2003 онд байгуулагдсан Ашгийн бус хувьцаат компанийн хэлбэртэй энэхүү сан нь баталгаа гаргагч даатгалын компани дампуурсан тохиолдолд захиалагч талын хохирлыг өөрийн хөрөнгөөс нөхөн олгодог. Энэ нь системд төрийн зүгээс үзүүлж буй хамгийн том баталгаа юм.

Г. Хуулийн хатуу зохицуулалт

Даатгалын компани гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Казахстаны Санхүүгийн зах зээлийг зохицуулах агентлаг нь тухайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл хатуу арга хэмжээ авдаг. Энэ нь захиалагч талуудад даатгалын баталгаанд итгэх итгэлийг хуулиар суулгаж өгсөн.

Д. Банкны монополь

Жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДҮ) банкнаас баталгаа авахын тулд хамаг хөрөнгөө барьцаалдаг байсан бол даатгалын баталгааг хуулиар тэгш эрхтэй болгосноор барьцаа хөрөнгийн дарамт буурч, бизнесийн идэвхжил нэмэгдсэн.

Сул тал:

Төрийн санхүүгийн нуруунд ирэх ачаалал (ФГСП - ийн эрсдэл)

“Даатгалын төлбөрийг баталгаажуулах сан” (ФГСП) нь даатгалын компаниуд дампуурахад өмнөөс нь мөнгө төлнө гэсэн хуультай.

- Хэрэв эдийн засгийн гүн хямрал болж, барилга эсвэл уул уурхайн салбарын олон компаниуд дагаад даатгалын томоохон компаниуд зэрэг дампуурвал **Төрийн хамгаалалтын сангийн мөнгө хүрэлцэхгүй болох** эрсдэлтэй. Энэ тохиолдолд төр өөрийн төсвөөс (татварын мөнгөнөөс) энэ алдагдлыг нөхөхөөс өөр аргагүйд хүрдэг.

Гадаадын компаниуд дотоодын зах зээлийг шахах аюул

2021 оны хуулиар гадаадын даатгалын том корпорацууд Казахстанд салбараа нээхийг зөвшөөрсөн.

- Санхүүгийн чадавхи, туршлагаар хамаагүй илүү гадаадын (Европ, Америк, Оросын) аварга компаниуд орж ирснээр Казахстаны дотоодын жижиг даатгалын компаниуд өрсөлдөөнд тэсэлгүй зах зээлээс шахагдах, дампуурах үйл явц эхэлсэн. Энэ нь үндэсний санхүүгийн салбарын хараат бус байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Хуулийн заалтууд амьдрал дээр зөрчилдөх

Хууль дээр “Даатгалын баталгаа нь банкны баталгаатай ижил хүчинтэй, маргаангүй төлөгдөнө” гэж заасан ч практикт энэ нь бүрэн хэрэгждэггүй.

- Даатгалын компаниуд хохирол гарах үед Иргэний хуулийн өөр нэг заалтыг ашиглан “Энэ нь даатгалын тохиолдол биш байна”, “Үйлчлүүлэгч өөрөө буруутай үйлдэл хийсэн” гэх мэтээр шалтаг зааж, төлбөр олгохоос татгалзах эсвэл шүүхээр заргалдаж цаг хугацаа хождог. Үүнээс болоод баталгааг хүлээн авагч (захиалагч) тал хохирч үлддэг.

Хэт төвлөрөл ба Монополь эрх

Даатгалын салбарыг цахимжуулж, хяналтыг чангатгасан нь (2022 оны хуулиар) салбарт хэтэрхий өндөр босго бий болгосон.

- Жижиг даатгалын компаниуд төрийн тавьж буй өндөр шаардлага, цахим системийн зардлыг дийлэхээ байж, зах зээл дээр зөвхөн төрийн хамааралтай эсвэл цөөн хэдэн олигархиудын эзэмшлийн 3-4-хөн том компани **монополь** болон үлдэх эрсдэлийг дагуулж байна. Монополь тогтсоноор даатгалын үйлчилгээний үнэ (хураамж) ирээдүйд өсөх сөрөг талтай.

Герман улсын даатгалын баталгааны талаархи хууль, эрх зүйн зохицуулалтууд

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) нь даатгалын баталгааны (**Kautionsversicherung** эсвэл **Bürgschaftsversicherung** буюу Батлан даалтын даатгал) хамгийн баялаг түүхтэй, олон улсад жишиг болсон сонгодог эрх зүйн тогтолцоотой орон юм. Германы эрх зүйн тогтолцоо нь даатгалын хамгаалалтын хоёр тусдаа баталгааны схемд тулгуурладаг. Тус улсын зохицуулалт, түүний үр нөлөө болон сул талуудыг нарийвчлан авч үзсэн.

ХБНГУ-ын даатгалын байгууллагуудад Bundesanstalt für Finanzdienstleistungsaufsicht (BaFin) хяналт тавьдаг бөгөөд тус байгууллага нь даатгалын компаниудын капиталын хүрэлцээ, төлбөрийн чадвар, эрсдэлийн төвлөрөл, нөхөн төлбөрийн чадавх зэрэгт маш хатуу хяналт хэрэгжүүлдэг.

Герман улсын даатгалын баталгааны эрх зүйн орчин нь:

- **Иргэний хууль (Bürgerliches Gesetzbuch – BGB)** - Германы Иргэний хууль (BGB) нь даатгалын баталгааны харилцааг бие даасан байдлаар бус, үүргийн гүйцэтгэлийг хангах суурь институтээр дамжуулан нарийвчлан зохицуулдаг. Практикт даатгалын компаниудаас гаргадаг баталгааны эрх зүйн үндэс нь BGB-ийн **Батлан даалт (Bürgschaft)**-ын зохицуулалт дээр тулгуурладаг.
- Даатгалын гэрээний тухай хууль (Versicherungsvertragsgesetz – VVG) - Даатгагч болон даатгуулагч хоорондын гэрээний эрх зүйн харилцааг ерөнхийд нь зохицуулдаг. Баталгааны даатгалын хувьд VVG нь даатгагч (Surety) болон үүрэг гүйцэтгэгч (Principal)-ийн хоорондох дотоод харилцааны эрх зүйн үндэс болдог. VVG нь даатгалын гэрээ байгуулах, даатгалын эрсдэлийг үнэлэх журам, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, хураамж төлөх болон гэрээ цуцлах нөхцөлийг зохицуулна.
- Даатгалын хяналтын тухай хууль (Versicherungsaufsichtsgesetz – VAG) - Баталгааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй байгуулагуудад тавих төрийн санхүүгийн хяналт шалгалтыг бүхэлд нь зохицуулдаг суурь хууль юм. VAG нь даатгалын байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, төлбөрийн чадварын шаардлага, капиталын хүрэлцээ, эрсдэлийн удирдлага болон санхүүгийн тайлагнал, аудитын харилцааг нарийвчлан тогтоодог.
- Европын холбооны Solvency II зохицуулалт - Европын Холбооны хэмжээнд мөрдөгддөг энэхүү удирдамж нь Германы даатгалын компаниудад хөрөнгийн

хүрэлцээний маш хатуу шаардлага тавьдаг. “Solvency II” нь эрсдэлд суурилсан капиталын тогтолцоо бөгөөд даатгагч нь гаргасан баталгааныхаа эрсдэлийн түвшнээс хамаарч цаанаа заавал байршуулах өөрийн хөрөнгийн хэмжээг тооцдог. Ингэснээр Германы даатгагчдын гаргасан баталгааг Евро бүсийн хэмжээнд найдвартай, эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөх баталгаа болдог. (Германд даатгалын байгууллагын төлбөрийн чадвар, капиталын хүрэлцээ болон эрсдэлийн удирдлагад тавих үндсэн шаардлага нь Европын Холбооны Solvency II тогтолцоонд суурилдаг бөгөөд уг шаардлагыг Герман улс Versicherungsaufsichtsgesetz (VAG)-аар дамжуулан үндэсний эрх зүйдээ хэрэгжүүлдэг.)

- Худалдааны хууль болон санхүүгийн хяналтын актууд - Германы Худалдааны хууль (Handelsgesetzbuch – HGB) болон Барилгын ажлын гүйцэтгэлийн үндсэн журам (VOB/B-ийн 17 дугаар зүйл)-аар даатгалын компанийн гаргасан батлан даалтыг банкны баталгаатай эрх зүйн хувьд яг ижил түвшинд авч үзэх заалтыг бататгаж өгсөн. Энэхүү зохицуулалт нь худалдаа, барилга, экспортын салбарт банкны монополийг задалж, аж ахуйн нэгжүүд банкны зээлийн шугамаа түгжихгүйгээр даатгалын уян хатан баталгааг ашиглан бизнесийн эргэлтийн хөрөнгөө чөлөөтэй удирдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниуд **Kautionsversicherung** (Баталгааны даатгал)-ын үйл ажиллагааныхаа хүрээнд Иргэний хуулийн **Bürgschaft** (Батлан даалт)-ын зарчмыг ашиглан, харилцагчдадаа **Bürgschaftsversicherung** (Даатгалын батлан даалт) гэдэг бүтээгдэхүүнийг олгодог.

Германы Даатгалын гэрээний тухай хууль (VVG)-ийн зохицуулалтын онцлогт хариулт нь байдаг. Германы хуулиар энэ 3 талт харилцааг хэрхэн хоёр тусдаа эрх зүйн гэрээгээр дамжуулж зохицуулдаг:

1. Дотоод харилцаа (Суурь гэрээ буюу VVG-ийн зохицуулалт) Даатгалын компани зүгээр явж байгаад хэн нэгний өмнөөс баталгаа гаргачихдаггүй. Хамгийн түрүүнд Surety (Даатгагч) болон Principal (Гүйцэтгэгч) хоёр хоорондоо уулзаж, баталгаа гаргах нөхцөл, хураамж (Premium)-аа тохирдог.

Энэхүү хоёр талын харилцааг Германы Даатгалын гэрээний тухай хууль (VVG) зохицуулдаг. Хуулийн үүднээс Surety-г “Даатгагч”, Principal-ийг “Даатгуулагч” гэж үзэж байгаа хэрэг юм.

2. Гадаад харилцаа (Бодит баталгаа буюу BGB-ийн зохицуулалт) Дээрх гэрээг байгуулж, хураамжаа авсны дараа Даатгалын компани (Surety) нь захиалагч буюу Obligee-д зориулж “Хэрэв Principal ажлаа хийхгүй бол би мөнгийг чинь төлнө” гэсэн Батлан даалтын хуудас (Bürgschaftsurkunde)-ыг бичиж өгдөг.

Энэхүү Surety болон Obligee хоорондын харилцааг Германы Иргэний хууль (BGB) зохицуулдаг.

Эрх Зүйн Тогтолцооны Үр Нөлөө (Ололт амжилт)

А. Банкны монополийг бүрэн задалсан нь

Германы хуулиар даатгалын баталгаа нь банкны баталгаатай тэгш эрхтэй тул ЖДҮ-үүд, барилгын компаниуд банкнаас үнэтэй баталгаа авах шаардлагагүй болсон. Даатгалын компаниуд барьцаа хөрөнгө (үл хөдлөх) бараг шаарддаггүй, харин тухайн компанийн санхүүгийн зэрэглэл, кредит түүхийг үндэслэж баталгаа гаргадаг тул бизнесийн хөрвөх чадварыг маш сайн дэмждэг.

Б. “Үл маргах журмаар шууд төлөх” (On-First-Demand) тогтолцоо

Германы даатгагчид “Bürgschaft na FIRST DEMAND” буюу захиалагч тал шаардсан даруйд ямар нэгэн маргаан үүсгэлгүйгээр төлбөрийг шууд олгодог баталгааг түгээмэл гаргадаг. Энэ нь захиалагч талуудад (ялангуяа төрийн болон томоохон корпорацуудад) даатгалын баталгаанд банкны адил 100% итгэх эрх зүйн баталгааг бүрдүүлсэн.

В. Кредит эрсдэлийн үнэлгээний туйлын өндөр чадавхи (Underwriting)

Германы даатгалын компаниуд аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг үнэлэхдээ банкуудаас илүү нарийн, уян хатан дата систем ашигладаг. Энэ нь санхүүгийн зах зээлийг эрүүл байлгахад маш том нөлөө үзүүлдэг.

3. Сул тал

А. Европын Холбооны “Solvency II” удирдамжийн хэт хатуу дарамт

Европын Холбооны санхүүгийн зохицуулалт болох “Solvency II” нь даатгалын компаниудаас асар их хэмжээний өөрийн хөрөнгө, бэлэн мөнгөний нөөц шаарддаг.

- **Сул тал:** Энэхүү хэт хатуу шалгуураас болоод жижиг, дунд даатгалын компаниуд баталгааны даатгалын зах зээлээс шахагдаж, зөвхөн “Allianz”, “Munich Re” зэрэг цөөн хэдэн дэлхийн хэмжээний байгууллагууд зах зээлийг монопольчлох хандлагатай болсон.

Б. Хэт хуучинсаг, консерватив систем (Цахимжуулалтын удаашрал)

Казахстан улстай харьцуулахад Герман улс нь хууль зүйн болон төрийн захиргааны практикт маш консерватив (хуучинсаг) ханддаг.

- **Сул тал:** Германд одоог хүртэл маш олон даатгалын баталгааг цаасан хэлбэрээр үйлдэж, шуудангаар илгээх, биечлэн баталгаажуулах үйл явц байсаар байна. Энэ нь орчин үеийн дижитал эдийн засагт цаг хугацаа алдах, хүнд суртал үүсгэх сул тал болдог.

В. Гэрээний эрх зүйн нарийн төвөгтэй байдал

Германы Иргэний хууль (BGB) болон VOB/B журам нь маш нарийн, хууль зүйн өндөр хэллэгтэй тул жижиг компаниуд баталгааны гэрээний нарийн заалтуудыг бүрэн гүйцэд ойлголгүй зөрчих, үүнээсээ болж даатгагч болон үйлчлүүлэгч хооронд маш урт хугацааны шүүхийн маргаан (Процессын хугацаа урт) үүсэх эрсдэл өндөр байдаг.

Г. Эдийн засгийн мөчлөгөөс хамаарах хамаарал (Салбарын хямрал)

Германы баталгааны даатгал нь үндсэндээ барилга, үйлдвэрлэлийн салбарт тулгуурладаг. Евро бүсийн инфляци, барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалаад Германы барилгын салбарт гэрээний үүргээ биелүүлж чадахгүй байх болох тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Энэ нь даатгалын компаниудад нэгэн зэрэг асар том хохирлын нөхөн төлбөрийн дарамт авчрах эрсдэлийг үүсгэж байна.

САНАЛ

Судалгааны үр дүнд тулгуурлан Монгол Улсад даатгалын баталгааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, практик хэрэглээг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор дараах саналуудыг дэвшүүлж байна:

Даатгалын баталгааны нэгдсэн мэдээллийн сан бий болгох

Одоогоор захиалагч байгууллага тухайн баталгаа хүчинтэй эсэх, өмнө нь хэдэн баталгаа гаргасан эсэх, нийт эрсдэлийн хэмжээ хэд байгаа талаар шууд шалгах боломж хязгаарлагдмал. Иймээс СЗХ-ны дэргэд даатгалын баталгааны нэгдсэн бүртгэл, цахим мэдээллийн сан бий болгож, баталгаа хүлээн авагч байгууллагууд тухайн баталгааны хүчин төгөлдөр байдал, хугацаа, давхар даатгалын мэдээллийг цахимаар шалгах боломж бүрдүүлэх.

Иргэний хууль болон Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах:

Иргэний хуулийн үүргийн гүйцэтгэлийг хангах аргын доторх "Баталгаа"-ны зохицуулалтаас тусад нь "Даатгалын баталгаа”-ны бие даасан эрх зүйн институтийн мөн чанар, гэрээний нөхцөлт шинжийг ялгаж өгөх. Даатгалын тухай хуульд даатгалын баталгаа гаргах үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлага, андеррайтингийн үнэлгээний суурь зарчмыг тусгах.

Давхар даатгалын шалгуурыг чангатгах, хяналтын журмыг шинэчлэх:

СЗХ-оос даатгалын баталгааны бүтээгдэхүүнд тавих хяналтыг чангатгаж, эрсдэлийг шилжүүлэн авч буй гадаадын давхар даатгагч байгууллага нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зээлжих зэрэглэлтэй (A-, B++ гэх мэт) мэргэжлийн давхар даатгагч байх шаардлагыг журамд тусгайлан зааж өгөх. Зөвхөн цаасан дээрх гэрээгээр эрсдэл шилжүүлэхийг хязгаарлах.

Төрийн худалдан авах ажиллагааны хуульд өөрчлөлт оруулах:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулж, тодорхой хэмжээнээс дээш үнийн дүнтэй тендерт даатгалын баталгааг хүлээн авах тохиолдолд захиалагч нь тухайн даатгалын компанийн төлбөрийн чадвар, капиталын хүрэлцээний талаар СЗХ-ноос заавал албан ёсны лавлагаа авч, баталгаажуулдаг байх шууд үүргийг хуульчлах.

Даатгалын синдикат болон хөрөнгийн чадавхыг дэмжих:

Дотоодын даатгалын зах зээлийн хөрөнгийн төвлөрөл бага, томоохон эрсдэлийг дангаар даах чадамж сул байгааг шийдвэрлэхийн тулд даатгалын компаниуд хамтран "Даатгалын синдикат" байгуулах эрх зүйн орчныг тодорхой болгож, Иргэний хууль болон Өрсөлдөөний тухай хууль хоорондын уялдааг хангах (картель гэж үзэхгүй байх зохицуулалт хийх).

Даатгалын маргаан шийдвэрлэх тусгай механизмыг бүрдүүлэх

Даатгалын гэрээ, нөхөн төлбөр, даатгалын баталгааны хэрэгжилттэй холбоотой маргааныг шүүхээс өмнөх шатанд түргэн шуурхай, зардал багатай шийдвэрлэх зорилгоор Даатгалын омбудсмен эсхүл даатгалын салбарын хараат бус эвлэрүүлэн зуучлах тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх боломжийг судлах. Ингэснээр даатгуулагч, ашиг хүртэгчийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн ачааллыг бууруулах, даатгалын салбарын талаарх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх боломжтой. Гэхдээ одоогоор тусдаа байгууллага байгуулахын оронд “СЗХ-ны дэргэд даатгалын маргааныг шийдвэрлэх тусгай зөвлөл” байгуулах нь илүү зохимжтой бөгөөд цаашид зах зээл өргөжихийн хэрээр бие даасан омбудсмений институт болгон хувиргах үе шаттайгаар явах.

ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын даатгалын баталгааны эрх зүйн орчин, онолын суурь, практикт үүсэж буй хүндрэл бэрхшээл болон олон улсын жишгийг харьцуулан шинжилсний үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг гаргаж байна:

Монгол Улсын 2002 оны Иргэний хуулиар зохицуулагдсан “баталгаа” (independent guarantee)-ны институт болон “даатгалын баталгаа” (surety bond)-ны эрх зүйн мөн чанар, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, банкны баталгаанаас ялгагдах шинж чанарыг хууль тогтоомжийн түвшинд нарийвчлан зааглаж өгөөгүй байна. Үүнээс шалтгаалан практикт даатгалын баталгааг Иргэний хуулийн үл маргах журмаар шаардах эрх бүхий "баталгаа" гэж үзэх үү, эсвэл нөхцөлт шинжтэй даатгалын гэрээ гэж үзэх үү гэдэг дээр хууль хэрэглээний ноцтой зөрүү үүсэж байна.

Даатгалын баталгаа нь өндөр дүнтэй санхүүгийн эрсдэл агуулдаг тул эрсдэлийг давхар даатгалын тогтолцоогоор олон улсын зах зээлд тараан байршуулах шаардлагатай байдаг. Гэвч практикт том хэмжээний эрсдэлийг олон улсын нэр хүнд бүхий давхар даатгагчид бус, санхүүгийн чадавх нь тодорхойгүй этгээдүүдэд шилжүүлэх замаар зөвхөн хэлбэрийн шаардлага хангах тохиолдол үүсч болох бөгөөд энэ нь баталгааны бодит найдвартай байдлыг сулруулах эрсдэлийг бий болгож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд захиалагч тал даатгалын компанийн санхүүгийн бодит чадамж, СЗХ-ны үзүүлэлт, лавлагааг заавал нягтлах хууль зүйн шууд үүрэг хүлээдэггүй байна. Энэ нь улсын төсвийг эрсдэлд оруулж, хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ дутуу хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоо тодорхой бус болох нөхцөлийг бүрдүүлж байна.

ХБНГУ, АНУ болон Европын Холбооны орнуудын туршлагаас үзэхэд даатгалын баталгааны тогтолцооны үр нөлөө нь зөвхөн баталгаа гаргах эрхээр бус, харин төлбөрийн чадварын хатуу хяналт, эрсдэлд суурилсан капиталын шаардлага, давхар даатгал болон хамтран даатгалын нарийвчилсан зохицуулалтаар хангагддаг байна. Харин Монгол Улсад FIDIC болон EPC гэрээний практик хэрэглээ нэмэгдэж байгаа боловч андеррайтингийн үнэлгээ, синдикатын эрх зүйн орчин, даатгалын баталгааны тусгайлсан зохицуулалт хангалттай хөгжөөгүй байгаа нь зах зээлд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байна.

НОМЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Иргэний хууль, 2002 он.
2. Иргэний хууль, 1994 он.
3. Даатгалын тухай хууль, 2004 он
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, 2023 он
5. Монгол Улсын Өрсөлдөөний тухай хууль, 2010 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Санхүүгийн зохицуулах хороо. “Даатгагчийн баталгаа” зурагт хуудас, Цуврал №25. Улаанбаатар, 2024 он.
2. Ж.Оюунтунгалаг. “Баталгаа”. Legaldata.mn, 2016 он.
3. “Монгол Улсын Иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001–2002)”. Улаанбаатар, 2018 он.
4. М.Хүслэн. “Даатгалын синдикат”. Судалгааны өгүүлэл, Улаанбаатар, 2025 он.
5. Санхүүгийн зохицуулах хороо. Даатгалын салбарын статистик тайлан. Улаанбаатар, 2024–2025 он.
6. Худалдан авах ажиллагааны газар. Төрийн худалдан авах ажиллагааны тайлан. Улаанбаатар, 2024 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Wills D. Morgan. *The History of Suretyship*. Cornell Law Review, 1927.
2. Jürgen Basedow. *Principles of European Insurance Contract Law (PEICL).* Munich: Sellier European Law Publishers, 2009.
3. OECD. *Working Papers on Finance, Insurance and Private Pensions*, No. 31. Paris, 2013.
4. World Bank & International Monetary Fund. *Insurance Guarantee Schemes (IGS) Report.* Washington D.C., 2023.
5. International Chamber of Commerce (ICC). *Uniform Rules for Demand Guarantees (URDG 758).* Paris, 2010.
6. UNCITRAL. *United Nations Convention on Independent Guarantees and Stand-by Letters of Credit.* New York, 1995.
7. FIDIC. *Conditions of Contract for Construction (Red Book).* Second Edition, 2017.

8. FIDIC. *Conditions of Contract for Plant and Design-Build (Yellow Book).* Second Edition, 2017.
9. FIDIC. *Conditions of Contract for EPC/Turnkey Projects (Silver Book).* Second Edition, 2017.
10. Viking Bond Service. *Surety Bond Infographic.* 2016.
11. The National Association of Surety Bond Producers (NASBP). *Surety Information Guide.* Washington D.C., 2020.
12. American Surety Co. v. Pauly, 170 U.S. 133 (1898).
13. Miller Act, 40 U.S.C. §§ 3131–3134, United States Congress, 1935.
14. Heard Act, United States Congress, 1894.

4. Олон улсын эрх зүйн баримт бичиг

1. ICC. *Uniform Rules for Demand Guarantees (URDG 758).*
2. UNCITRAL. *United Nations Commission on International Trade Law* materials.
3. FIDIC. *Red Book, Yellow Book, Silver Book*, Second Edition, 2017.
4. EU Insurance Contract Law materials.
5. US Surety Bond Law materials.